

## ГАРЧИГ

1. **Монгол улс дахь хүний амьд явах эрх түүний эрх зүйн баталгаа**  
(академич С.Нарангэрэл)
2. **Монгол улсад цаазаар авах ялыг хэрэглэсэн байдлын судалгаа**
  - 2.1 Монгол улсын хууль тогтоомж дахь цаазаар авах ял (түүхэн тойм) (академич С.Нарангэрэл, докторант Б.Амарбаясгалан)
  - 2.2 Цаазаар авах ял ба улс төрийн хэлмэгдэл (академич С.Нарангэрэл, доктор Н. Сампилноров)
  - 2.3 Монгол улсын дагаж мөрдөж буй 2002 оны Эрүүгийн хууль дахь цаазаар авах ял (академич С.Нарангэрэл, докторант Г.Эрдэнэбат)
  - 2.4 Цаазаар авах ял ба Монголын шүүхийн практик (академич С.Нарангэрэл, магистр Б.Дангаасурэн)
3. **Цаазаар авах ялтай хэргийн Монгол улс дахь шүүн таслах ажиллагаа**
  - 3.1 Цаазаар авах ялтай хэргийн мөрдөн байцаалт (академич С.Нарангэрэл, докторант Р. Оюунбадам)
  - 3.2 Цаазаар авах ялтай хэргийн шүүх хуралдаан (академич С. Нарангэрэл, докторант Б.Амарбаясгалан)
  - 3.3 Цаазаар авах ялыг давж заалдах эрх (академич С.Нарангэрэл, докторант Р. Оюунбадам)
  - 3.4 Цаазаар авах ялын талаархи уучлалт (докторант Р.Оюунбадам, М.Алтангэрэл)
  - 3.5 Цаазаар авах ялын хүлээлт (докторант Р.Оюунбадам)
  - 3.6 Цаазаар авах ялын гүйцэтгэл (докторант Р.Оюунбадам)
4. **Цаазаар авах ялын дэлхий дахины нийтлэг чиг хандлага** (Б.Алтантуяа, Р. Оюунбадам)
5. **Цаазаар авах ялд хийсэн тандалтын судалгаа (социологийн судалгаа)**
  - a. Удиртгал (академич С.Нарангэрэл, докторант Г.Эрдэнэбат, Б.Амарбаясгалан)
  - b. Мэргэжлийн хуульчдын хандлага (академич С.Нарангэрэл, докторант Г.Эрдэнэбат, Б.Амарбаясгалан)
  - c. Олон нийтийн хандлага (академич С.Нарангэрэл, докторант Г.Эрдэнэбат, Б.Амарбаясгалан)

5.4 Дүгнэлт (академич С.Нарангэрэл)
6. **Зөвлөмж** (академич С.Нарангэрэл, Б.Алтантуяа)

## **Өмнөх үг**

“Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял” гэсэн эл бүтээлийг боловсруулан гаргах ажил үйлсийг хүний эрхийн олон улсын нэр хүнд бүхий томоохон хөдөлгөөн болох “Эмнести Интернэшнл” байгууллагын Монгол улс дахь салбар санаачилж, зохих санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд АНУ-ын Эмнести Интернэшнл тусалсан юм.

Танд толилуулж буй эл товхимолд Монгол улс дахь хүний амьд явах эрх ба түүний эрх зүйн баталгаа; Монгол улсад цаазаар авах ялыг хэрэглэсэн байдлын судалгаа (түүхэн тойм); цаазаар авах ял ба улс төрийн хэлмэгдэл; Монгол улсын дагаж мөрдөж буй 2002 оны Эрүүгийн хууль дахь цаазаар авах ял; Цаазаар авах ял ба Монголын шүүхийн практик; Цаазаар авах ялтай хэргийн Монгол улс дахь шүүн таслах ажиллагаа; Цаазаар авах ялын дэлхий дахины нийтлэг чиг хандлага зэрэг асуудлыг хөндсөн болно. Тэрчлэн цаазаар авах ялын талаар тандалтын судалгааг мэргэжлийн хуульчид ба иргэдийн дунд явуулав. Энэхүү судалгааг Монгол улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 4344 иргэн, 558 хуульч буюу, өөрөөр хэлбэл 5 мянга шахам хүний дунд явуулсан бөгөөд ийм томоохон хэмжээний судалгаа эрх зүйн салбарт урьд нь бараг хийгдэж байгаагүй болно. Эл судалгааны дүгнэлт болон бусад материал цаашдаа ч их хэрэг болно гэдэгт бид эргэлзэхгүй байна.

Судалгааны материалыг олж цугларуулах, нэгтгэн дүгнэх, бичихэд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын Дээд шүүхийн судалгааны төв, Монгол улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс Монголын Эмнести Интернэшнл байгууллагатай хамтран ажилласныг тэмдэглэхэд нэн таатай байна.

Монголын Эмнести Интернэшнл олон улсын хүний  
байгууллагын удирдах зөвлөлийн дарга, академич  
С.НАРАНГЭРЭЛ

**UHN.MN**  
СУДАЛГААНЫ САН

## 1. Монгол улс дахь хүний амьд явах эрх, түүний эрх зүйн баталгаа

Цаазаар авах ялын талаархи олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн стандарт нь юуны өмнө Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын хэм хэмжээ бөгөөд түүний 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах ... эрхтэй” гэж заасан байдаг. Эл эрхийг улам тодорхой болгож, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 6 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй. Цаазаар авах ялыг цуцлаагүй улсад уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир энэхүү Пакт болон Төрлөөр устгах гэмт хэргээс

• урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцийн заалтад нийцсэн бөгөөд тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу тухайн этгээдэд оногдуулж болно. Энэхүү ялыг эрх бүхий шүүхийн эцсийн шийдвэрийн дагуу гүйцэтгэж болно.” хэмээн заасан байна. Эдгээр хэм хэмжээ нь юуны түрүүнд төрийн зүгээс хүний амь насыг хууль бусаар бусниулж хэрхэвч болохгүй гэсэн утга санааг илэрхийлдэг.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн эл стандартыг 1990 он хүртэл Монгол улсад хүлээн зөвшөөрдөггүй, үндэснийхээ хууль тогтоомжид тусгаагүй ирсэн төдийгүй иргэдийнхээ амь насыг хоморголон бөөнөөр нь хөнөөж байсан түүхэн үнэн баримт удаа дараа гарч байсан юм.

Монгол улсад ардчилал, хүний эрх, шинэчлэлийн төлөө хөдөлгөөн хүчтэй өрнөж эхэлснээр Үндсэн хууль ба үндэсний бусад хууль тогтоомжид хүний амьд явах эрхийг хуульчлах бодит нөхцөл бүрдсэн бөгөөд үүнийг эдүгээ Монгол улсын хууль тогтоомжид дараахи байдлаар тусган илэрхийлсэн байна.

Монгол улсын Үндсэн хуулийн (1992 оны) “хүний эрх, эрх чөлөө” хэмээн нэрлэсэн II бүлгийн 16 дугаар зүйлийн 1) -т хүн бүр “амьд явах эрхтэй. Монгол улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ ногдуулснаас бусад тохиолдолд хүний амьд нас бусниулахыг хатуу хориглоно” гэж заажээ. Хүний үндсэн эрх болох амьд явах эрхийн гол онцлог шинж нь жирийн хүмүүсийн хоорондын харилцаанд биш, төр нийгэмтэй харилцахад буюу нэг талд нь хүн, хүмүүсийн нэгдэл (хуулийн этгээд, ТББ зэрэг) нөгөө талд нь засаг төр гэсэн нарийн төвөгтэй харилцаанд хамаарч, илэрч хэрэгждэг, бас зөрчигддэг байна. Энэ учраас хүний амьд явах эрх бол юуны өмнө засаг төрөөс хууль бусаар буюу дур зоргоороо хүний амьд насыг бүрэлгэхийг хатуу хориглоно гэсэн тайлбарыг дийлэнхи судлаачид хийж байна.<sup>1</sup> Ийнхүү Монгол улсын Үндсэн хуулийн хүний амьд явах эрхийн талаархи заалт олон улсын хүний эрхийн нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн стандартад хэмжээнд хүрсэн байна.<sup>2</sup>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>1</sup> (Чимид.Б, Үндсэн хуулийн үзэл баримтлал..., Улаанбаатар., 2002, 95 дахь талаас үз.)

<sup>2</sup> (Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал.2001..., Улаанбаатар., 75 дахь талаас үз.)

## **2. и Монгол улсад цаазаар авах ялыг хэрэглэсэн байдлын судалгаа**

### **1.1 Монгол улсын хууль тогтоомж дахь цаазаар авах ял (түүхэн тойм)**

Цаазаар авах ял Монгол улсад өнө эртнээс өргөн хэрэглэгдэж ирсэн ялын нэгэн төрөл мөн. Эзэн Чингис хааны “Их засаг хууль” болон Юань гүрний нэвтэрхий хууль, Монгол-ойродын цааз бичиг, Халх журам, Монгол цаазын бичиг, Гадаад Монголын хууль зүйлийн бичиг, Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг зэрэг Х1И-Х1Х зууны сүүлч хүртлэх эртний хуульд цаазаар авах ялыг нэлээд өргөн хүрээтэй хэрэглэж байсан байдал судалгааны үр дүнгээр тодорхой болсон юм.

Дэлхийн их эзэнт гүрэн байсан Монгол улс задран бутарч улмаар 200 гаруй жилийн турш Манжийн колоничлолд байснаа 1921 онд тусгаар тогтнолоо олж авсан билээ. Тэр үеийн Ардын Засгийн газар 1921 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 7 дугаар хуралдааны тогтоолоор алах ялыг эх орноосоо урвах, хувьсгалын эсэргүү гэмт хэрэг, цэргийн зарим хүнд гэмт хэрэглэхээр болсон байна. Ардын Засгийн газар 1923 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Эрүүгийн хуулийг боловсруулж, дагаж мөрдөх хүртэл зэвсэг хэрэглэсэн дээрэм, шунахай зорилгоор хүн алсан хэрэгт цаазаар авах ял ногдуулахаар шийдвэрлэж байжээ.

Монгол улс 1926, 1929, 1934, 1942, 1961, 1987 (шинэчлэн найруулсан), 2002 онд Эрүүгийн хууль баталж, дагаж мөрдүүлж ирсэн.

1926 оны Эрүүгийн хууль (Шүүх цаазны бичиг хэмээн нэрлэж байсан) -д улс төрд тэрсэлсэн онц аюултай гэмт хэргүүд (41-44 дүгээр зүйл); улс төрөөс урвасан гэмт хэргүүд (49-50 дугаар зүйл); гадаад улсын элчин, тэдгээрийн төлөөлөгчдийг алах (52 дугаар зүйл); гадаад улсад суугаа тус улсын элчин зэрэг түшмэдийг алах (56 дугаар зүйл); албан тушаалтны шийдвэр, тушаалыг эсэргүүцэх, тэдэнд хүч хэрэглэх, алах (65 дугаар зүйл); улсын зоос ба мөнгөн тэмдэгт цаасыг дууриалган хуурамчаар үйлдэх (133 дугаар зүйл); эх эцгээ алах (169 дүгээр зүйл); бусдыг хүндрүүлэх шалтгаантайгаар санаатай алах (170 дугаар зүйл); зэвсэг хэрэглэн дээрэмдэж хүн алах (212 дугаар зүйл) зэрэг гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Ийнхүү эрүүгийн хуулийн 13 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр заасан аж. Эдгээр хэргүүдэд цаазаар авах ялыг өөр ялын сонголтгүйгээр туйлын тодорхой санкцын байдлаар тогтоосон онцлогтой. Үүнээс шууд шалтгаалж цаазаар авах ялыг өргөн хэрэглэх, шууд гүйцэтгэх эрх зүйн үндэс тавигдсан юм. Хуульд цаазаар авах ялыг хэрэшэж үл болох субъектүүдийн талаар тодорхой заалт байгаагүй учраас эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүүхэд, хөгшин настай хүмүүст эл ялыг ногдуулахыг үгүйсгэхгүй байжээ.

1929 оны Эрүүгийн хууль (Шүүх цаазны бичиг хэмээн нэрлэж байсан) -д ардын хувьсгалд тэрсэлсэн онц аюултай гэмт хэргүүд (42-45, 48 дугаар зүйл); улс төрөөс урвасан гэмт хэргүүд (50-51 дүгээр зүйл); гадаад улсын элчин, тэдгээрийн төлөөлөгчдийг алах (53 дугаар зүйл); гадаад улсад суугаа тус улсын элчин зэрэг төлөөний түшмэдийг алах (56 дугаар зүйл); хорлон сүйтгэх (58 дугаар зүйлийн 1); албан тушаалтны шийдвэр, тушаалыг эсэргүүцэх, тэдэнд хүч хэрэглэх, алах (70 дугаар зүйл); улсын зоос ба мөнгөн тэмдэгт цаасыг дууриалган хуурамчаар үйлдэх (135 дугаар зүйл); онц хүндрүүлэх бүрэлдүүнтэйгээр албан тушаалтан зэрэг хүмүүс онц эрх бүхий этгээд болох буюу улсын онц үнэ бүхий чухал зүйлийг ашиглах зэргээр сүйтгэсэн (157 дугаар зүйл); буу зэвсэг хэрэглэн дээрэмдэж хүн алах (214 дугаар зүйл) зэрэг гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Хүндрүүлэх

шалтгаантайгаар хүнийг санаатай алах гэмт хэрэгт тогтоосон цаазаар авах ялыг хассан байна. Ийнхүү эрүүгийн хуулийн 14 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоож, өмнөх хуулиас цаазаар авах ял хэрэглэж болох хэргийн тоо 2-оор нэмэгдсэн байна. Өмнө дурдсан гэмт хэргүүдэд цаазаар авах ялыг өөр сонголтгүйгээр туйлын тодорхой санцрын байдлаар тогтоожээ. Мөн хуульд цаазаар авах ялыг хэрэглэж үл болох субъектүүдийн талаар тодорхой заалт оруулж “гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй хүмүүс, хөхүүл хүүхэдтэй, жирэмсэн эмэгтэйд цаазаар авах ял хэрэглэж болохгүй” хэмээн заасан байна. Үүнээс үзэхэд эмэгтэйчүүдэд цаазаар авах ялыг ногдуулж байжээ.

1934 оны Эрүүгийн хууль (Шүүх цаазны бичиг хэмээн нэрлэж байсан) -д хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд (42-47 дугаар зүйл); засаг захиргааны журмыг эсэргүүцсэн онц аюултай гэмт хэргүүд (55.1, 52, 54 дүгээр зүйл); хүндрүүлэх бүрэлдүүнтэйгээр албан тушаалтан нь түүнд олгосон онц хариуцлага бүхий хүн улсын онц чухал үнэ бүхий зүйлүүдийг хувьд ашигласан буюу эсхүл ашигласан, үрэгдүүлсэн, энэ нь улсын эдийн засагт хорт санаатайгаар үйлдэгдсэн (100 дугаар зүйл); бусдыг хүндрүүлэх шалтгаантайгаар санаатайгаар алсан (118 дугаар зүйл); мал хулгайлсан (139.4 дүгээр зүйл); онц хүндрүүлэх шалтгаантайгаар бусдын эд хөрөнгийг илтээр хулгайлж, дээрэмдэх (141 дүгээр зүйл); цэргийн албаны хүмүүсээс өдүүлсэн гэмт хэргүүд (157, 160, 162, 167, 168, 169, 171, 172, 174 дүгээр зүйл) зэрэг гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Ийнхүү эрүүгийн хуулийн 21 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоож, өмнөх хуулиас 7-гоор нэмэгджээ. Өмнө дурдсан гэмт хэргүүдэд цаазаар авах ялыг өөр сонголтгүйгээр туйлын тодорхой санцрын байдлаар тогтоожээ. Мөн хуулийн 17 дугаар зүйлд “Буудан алах ял болвоос улсыг хамгаалах онц арга хэмжээ мөн учир туйлын хүнд гэмт хэрэгт хэрэглэх бөгөөд басхүү шүүн таслах газраас ялтан этгээдэд мөнхүү гэмт хэрэг дахин үйлдэхийг цээрлүүлэх өөр аргагүй хэмээн бодсон буюу ард түмний дайсан этгээдийг айлган цээрлүүлэх өөр аргагүй хэмээн бодсон буюу ард түмний дайсан этгээдийг айлган сүрдүүлэх онц чухал учир тохиолдсон тухайд хэрэглэнэ” гэж заажээ. Хуулийн энэ заалтаас үзэхэд улс төрийн талаар өөрөөр сэтгэгчдийг хайр найргүй цээрлүүлнэ гэсэн санааг илэн далангүй шууд хуульчилсан нь тодорхой хоёрдмол утга санаагүйгээр шууд илэрхийлэгдсэн байдаг. Эрүүгийн хуулийн эл заалт 1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлтийн эрх зүйн суурь үндэс болсон байна. “Гэмт хэрэг үйлдэх цаг үед насанд хүрээгүй хүмүүс ба жирэмсэн ба хөхүүл нялхастай эмэгтэйчүүдэд” цаазаар авах ял ногдуулахыг хориглосон заалтыг эл хуульд оруулж байжээ. Монгол улсын Сайд нарын Зөвлөлийн 1937 оны 3 дугаар сарын 19-ний 9 дүгээр хуралдаан, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн мөн оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 16 дугаар хуралдаанаар Шүүх цаазны бичигт нэмэлт өөрчлөлт оруулан тээврийн жолооч нар дүрэм заавар зөрчиж онц их хэмжээний хохирол учруулсан буюу хүний амь насыг бусниулсан бол хүндрүүлэх шалтгаантай бол цаазаар авах ял ногдуулахаар тогтоожээ. Ийнхүү болгоомжгүй гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр зааж байжээ. Тэрчлэн үндэстний ба шашны талаар өширхөх буюу эвдрэл гаргахад чиглэгдсэн ухуулга хийх, мөн ийм утга агуулгатай бичиг зохиолыг бэлтгэх буюу тараах, хадгалах үйлдлийг байлдааны буюу тайван биш цагт үйлдсэн бол цаазаар авах ял ногдуулахаар тогтоожээ. Ийм байдлаар цаазаар авах ял ногдуулж болох хэргийн хүрээг улам бүр өргөжүүлсээр байлаа.

1942 оны Эрүүгийн хуульд хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд (55-57, 59-67, 69 дүгээр зүйл); засаг захиргааны журмыг эсэргүүцсэн бөгөөд БНМАУ-д онц аюул бүхий гэмт хэргүүд (72-74, 76-77, 79 дүгээр зүйл); хэргийг зөв шийдвэрлэх явдалд буюу албан

байгууллагын ажил явуулгад саадыг учруулах, энэ нь хүндрүүлэн үзэх шалтгаантай бол (100 дугаар зүйл); хоригдон байгаа этгээд харгалзуулсан манааны хүмүүсийн бие махбодийг хүнд гэмтээж аминд аюултайгаар эрүүл мэндийг сарниулсан буюу амийг сүйтгэсэн (103 дугаар зүйл); албан тушаалтнаас засгийн буюу албан тушаалын эрхийг хэр хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэх энэ нь хүндрүүлэн үзэх шалтгаантай бол (124 дүгээр зүйл); албан тушаалтан улсын онц чухал үнэ бүхий зүйлүүдийг хувьдаа ашигласан буюу үрэгдүүлсэн ба энэ нь хүндрүүлэн үзэх шалтгаантай (128 дугаар зүйл); аливаа хүнийг хууль бусаар баривчлах энэ нь хүндрүүлэн шалтгаантай байвал (129 дүгээр зүйл); бусдыг хүндрүүлэх шалтгаантайгаар бусдыг алсан (148 дүгээр зүйл); хүндрүүлэх шалтгаантайгаар хүчиндсэн (164 дүгээр зүйл); хүндрүүлэх шалтгаантай мал хулгайлсан (173.5 дугаар зүйл); хүндрүүлэх шалтгаантайгаар дээрэмдэх (176 дугаар зүйл); бусдын эд хөрөнгийг санаатайгаар сүйтгэх буюу гэмтээсэн нь хүндрүүлэн үзэх шалтгаантай бол (182 дугаар зүйл); цэргийн гэмт хэргүүд (195.3, 195.4, 196.3, 197.3, 199.3, 200.3, 202, 204.1, 206.3, 207.4, 208-2, 211.2, 212, 213.2, 215.2, 216 дугаар зүйл) зэрэг гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Ийнхүү эрүүгийн хуулийн 44 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоосон нь өмнөх эрүүгийн хуулиас цаазаар авах ял хэрэглэж болох хэргийн тоог хоёр дахинаар нэмэгдүүлсэн явдал болжээ. Ийм байдалд хүргэхэд цэргийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг өргөн хэрэглэхээр болсон нь шууд нөлөөлжээ. “Хувьсгалт төр засаг хийгээд улс нийтэд онц аюул бүхий хүнд гэмт хэргүүдтэй хатуугаар тэмцэхийн тулд хуулийн зүйлүүдэд тусгайлан заасан байвал улс нийтийг хамгаалахын тулд туйлын арга болох буудан алах ялыг хэрэглэнэ” гэж энэ эрүүгийн хуульд заасан байна. Харин уг гэмт хэргийг үйлдэх үед 18 насанд хүрээгүй байсан хүмүүс ба бие жирэмсэн буюу хөхүүл хүүхэдтэй хүмүүст цаазаар авах ял ногдуулахыг эл хуулиар хоригложээ.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1947 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн “Улсын ба олон нийт, хоршооллын байгууллагуудын өмчийг хамгаалах тухай” 5 дугаар тогтоолд улсын ба олон нийт, хоршооллын байгууллагын өмчийг онц хортой аргаар буюу зохион байгуулалттайгаар мөн түүнчлэн улсын ба олон нийтийн мөнгөн хөрөнгө, үнэ бүхий бусад эд материалыг үлэмжхэн хэмжээгээр хулгайлсан, шамшигдуулсан гэмт этгээдийг буудан алж байхаар тогтоожээ.

*Цаазаар авах ялыг хоромхон зуур хүчингүй болгосон нь* БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1953 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн “Алах ялыг өөрчлөх тухай” 93 дугаар зарлигт “БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс энх тайван цаг үед алах ялыг хойшид хэрэглэхийн хэрэггүй гэж үзнэ” заажээ. Эл зарлигаар БНМАУ-д дагаж шийтгүүлж байгаа хуулиудаар тогтоосон алах ялыг хэрэглэхгүй болгож, зөвхөн эх орноос урвагчид, тагнуулчид, хорлон сүйтгэгч нарт хэрэглэж байхаар тогтоосон билээ. Харамсалтай нь цаазаар авах ялыг хүчингүй болгосон энэ заалт дөнгөж 10 орчим сар хэрэгжиж, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1954 оны 67 дугаар зарлигаар хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алсан гэмт хэрэгт буудан алах ял хэрэглэж байхаар тогтоожээ.

*1961 оны Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг онцгой ял хэмээн үзэж дараахи төрлийн гэмт хэрэгт хэрэглэхээр тогтоожээ.* Үүнд: эх орноосоо урвах (45 дугаар зүйлийн “а”); тагнуул хийх (46 дугаар зүйл); улс төрийн зорилгоор аллага хийх (47 дугаар зүйлийн “а”, “б”); хорлон сүйтгэх (48 дугаар зүйлийн “а”); онц хүндрүүлэх бүрэлдүүнтэйгээр улс, олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулах (63 дугаар зүйлийн “в”); бусдыг хүндрүүлэх шалтгаантайгаар санаатай алах (70 дугаар зүйл); онц хүндрүүлэх шалтгаантайгаар хулгай хийх (109 дүгээр зүйлийн “в”); цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын

гишүүдийн биед халдаж гэмтэл учруулах (155 дугаар зүйлийн “в”); онц хүндрүүлэх шалтгаантайгаар дээрэм хийх (168 дугаар зүйлийн “в”); хөдөлгөөнийг аюулгүй байлгах, автоторт буюу цахилгаан тээврийг ашиглах дүрэм зөрчих (174 дүгээр зүйлийн “в”) Ийнхүү эрүүгийн хуулийн 9 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Үүнийг 1942 оны эрүүгийн хуультай харьцуулахад цаазаар авах ял бүхий эрүүгийн хуулийн зүйлийн тоо 35-аар буурсан байна. Тэгэхдээ эх орноосоо урвах (45 дугаар зүйлийн “а”); тагнуул хийх (46 дугаар зүйл); хорлон сүйтгэх (48 дугаар зүйлийн “а”); онц хүндрүүлэх бүрэлдүүнтэйгээр улс.олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулах (63 дугаар зүйлийн “в”); онц хүндрүүлэх шалтгаантайгаар хулгай хийх (109 дүгээр зүйлийн “в”); цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдийн биед халдаж гэмтэл учруулах (155 дугаар зүйлийн “в”); онц хүндрүүлэх шалтгаантайгаар дээрэм хийх (168 дугаар зүйлийн “в”) зэрэг хүний амь нас хохируулаагүй буюу эд хөрөнгийн шинжтэй хохиролтой хэрэг, түүнчлэн бологомжгүй гэмт хэрэгт/ (хөдөлгөөнийг аюулгүй байлгах, автоторт буюу цахилгаан тээврийг ашиглах дүрэм зөрчих (174 дүгээр зүйлийн “в”) цаазаар авах ял хэрэглэх боломжийг шүүхэд олгож байсан билээ. Эл хуульд эмэгтэйчүүд болон шийтгэгдэх үед 60-аас дээш насны эрэгтэйчүүд мөн гэмт хэрэг үйлдэх үед 18 насанд хүрээгүй хүмүүст цаазаар авах ял ногдуулах явдлыг хоригложээ. Цаазаар авах ялыг хорих ялтай сонгож хэрэглэхээр тогтоосон байна.

1987 оны (шинэчлэн найруулсан) Эрүүгийн хуулиар эх орноосоо урвах (60 дугаар зүйл); тагнуул хийх (61 дүгээр зүйл); улс төрийн зорилгоор аллага хийх (62.1 дүгээр зүйл); улс төрийн зорилгоор гадаад улсын төлөөлөгчийн эсрэг аллага хийх (63.1 дүгээр зүйл); хорлон сүйтгэх (64 дүгээр зүйл); зандачлах (73 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (85 дугаар зүйл); хүчиндэх (112 дугаар зүйл); улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах (128 дугаар зүйл); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл); цагдан сэргийлэх байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдах (222 дугаар зүйл); агаарын хөлгийг авч зугатаах (268 дугаар зүйл) гэмт хэрэг хэрэгт цаазаар авах ял тогтоосон байна. Ийнхүү эрүүгийн хуулийн 12 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Мөн хуулиар 18 нас хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял ногдуулахыг хоригложээ.

1990 оноос хойшхи зарим шинэчлэлт БНМАУ-ын Бага Хурал 1991 онд “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль баталж, эд хөрөнгийн шинжтэй гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхийг хүчингүй болгосон нь цаазаар авах ялыг хэрэглэх хүрээг хумихад нэн чухал алхам болсон билээ.

Монгол улс 1992 онд шинэ Үндсэн хууль баталсантай холбогдуулан дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийг түүнтэй нийцүүлэх зүй ёсны шаардлага гарч ирсэн байна. Монгол Улсын Их Хурал 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдөр “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” баталж, өмнөх Эрүүгийн хуулиар 10 гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулж байсныг дараахи таван төрлийн гэмт хэрэгт эл ялыг тогтоосон байна: улс төрийн зорилгоор аллага хийх (62.1 дүгээр зүйл); улс төрийн зорилгоор гадаад улсын төлөөлөгчийн эсрэг аллага хийх (63.1 дүгээр зүйл); хорлон сүйтгэх (64 дүгээр зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (86 дугаар зүйлийн 2 дахь хэсэг); онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (112 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)

1998 онд УИХ-ын гишүүн Д.Хувьтөгөлдөр бүрэн эрхийнхээ дагуу Монгол улсын Эрүүгийн хуульд байгаа цаазаар авах ялыг халах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, УИХ-д өргөн барьсан боловч хууль сахиулах байгууллагууд болон хууль тогтоогчид дэмжээгүй тул төслөө парламентаар хэлэлцүүлэлгүй буцаан авч байжээ.

## **2.2Цаазаар авах ял ба улс төрийн хэлмэгдэл**

Цаазаар авах ялын олон улсын стандартын онцлог шинжийн нэг нь үйлдсэн гэмт хэрэгт гагцхүү шүүхийн шийтгэх тогтоолоор эл ялыг ногдуулах явдал мөн. Гэвч Монгол улсад коммунист дэглэм тогтосны дараа газар дээр нь буюу шүүхийн бус байгууллагын хууль бус шийдвэрээр хүмүүсийг бөөнөөр нь буудан хороож байсан юм. Тухайлбал Ардын Засгийн газрын 1923 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн улсын хуралдааны тогтоолоор төрд тэрсэлсэн гэж үзэж 10 гаруй хүнд ногдуулсан цаазаар авах ялыг баталж байжээ. Онцгой бүрэн эрхт комисс хэмээн нэрлэгдсэн шүүхийн бус байгууллага 1937 оны 9 сараас эхлэн 1939 оны 4 сар хүртлэх хугацаанд нийт 20474 хүнийг буудан алах шийдвэрийг гаргаж, улмаар гүйцэтгэсэн юм.

1920-оод оны эх үеэс Монгол улсын засаг төрийн удирдлага Коминтернийн эрхшээлд орсон үеэс эхлэн нам-дотоодыг хамгаалах байгууллагын шийдвэр ба бусад актаар хүмүүсийг газар дээр нь устгах, бөөнөөр нь цаазлахыг уриалж, ийм алхамд улайн цайм турхирч, энэ талаар олон нийтийн сэтгэл зүйг бэлтгэж эхэлсэн байна. Энэ нь тэр цаг үед цорын ганц зөв хэмээн хүлээн зөвшөөрч байсан марксист-ленинист сургаалиас улбаатай байсан юм. Марксист-ленинист сургаалийг үндэслэгчдийн нэг- В.И.Ленин “террорист цэвэрлэгээ хийж: шүүх газар дээр нь үг дуугүй буудан алж байх”, “цэргүүд, офицер байгсад, биеэ үнэлж явагсад зэргийг зуу зуугаар буудах ба хөөн гаргах... зэрэгт бүх хүчээ төвлөрүүлэх”<sup>3</sup>- ийг шаардаж байжээ. ЗСБНХОУ-ын Ардын Комиссаратын Зөвлөл 1918 оны 2 дугаар сарын 21-нд дайсны тагнуулууд, дамчид, танхайрагчид, хувьсгалын эсэргүү суртал нэвтрүүлэгчид ба германы туршуулуудыг шүүхгүйгээр газар дээр нь буудан алж байх зөвшөөрөл олдгож байжээ. 1921 оноос эхлэн Монгол улсын Засгийн газар, төрийн гол байгууллагуудад Коминтерний зөвлөхүүд ажиллах болсноор “улаан террор” -ыг Монгол улсад хуулбарлах болжээ. Ийнхүү улс төрийн хэлмэгдүүлэлт 1920-оод оны эх үеэс Монгол улсад эхэлж, 1922 онд 6, 1923 онд 1, 1924 онд 2 хүнийг буудан алсан тохиолдол бүртгэгдсэн нь албан ёсны тоо баримтад байгаа боловч 1930-аад оны үеэс нийтийг хамарсан шинжтэй болж хувирсан байна.

1937 оны 3 дугаар сарын 17-нд Дотоод Явдлын яамны (ДЯЯ) сайд Х.Чойбалсангийн гаргасан 17 тоот тушаалд “...тус улсын нам засгаас туйлын чухал байлдааны ажлыг бидэнд хариуцуулсан болох учир тус яамнаас гаргасан тушаал зааврууд нь байлдааны чанартай тушаал зааврууд хэмээхийг сайтар мэдэх хэрэгтэй бөгөөд үнэндээ байлдааны тушаалыг гүйцэтгээгүй этгээдийг шууд ялын дээд хэмжээгээр хүртэл шийтгэхээр тус улсын шүүх цаазны бичигт заасан байх учир тус яамны байлдааны чанартай тушаалуудыг завхруулсан ажилчин гарах аваас тэд нарыг буудан алах хүртэл арга хэмжээ авч тушаалыг гүйцэтгүүлж чадна” гэж заасан байв. Удалгүй ДДЯамны сайд Х.Чойбалсан, дэд сайд Б.Лосол, тусгай хэлтсийн дарга Н.Насантогтох нарын гарын үсэг зурж баталгаажуулсан сануулга бичигт мөрдөн байцаалт явуулахдаа хэрэгтэн нэг бүрийн сул өвчтэй талыг ба айх буюу өөр зүйлийн байдлыг мэдэж, сул өвчтэй талыг нь ашиглан байцааж хэргийг хүлээлгэх, байцаагч нарын үндсэн зорилго

<sup>3</sup> (Ленин В.И. Полн. Собр. Соч. Т.30. с. 122; т.43. с.234; т.50. с.142 )



бол хэрэгтэн этгээд нарыг гартаа авч эзэрхэн ажиллах, дайсан этгээд хэчнээн хатуу байна, байцаагч нар түүнээс хатуу байх гэх зэргээр байцаалтыг ийм байдлаар явуулах зааварчилгаа өгч байжээ. Энэ нь хүмүүст эрүү шүүлт тулгах, дээд зэргээр хүнлэг бус, харгис хэрцгий харьцах, хүний нэр төрийг доромжлон гутаах арга хэрэглэхийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, төрийн бодлогын хэмжээнд тавьсан хэрэг байлаа.

ДЯЯамны сайд Х.Чойбалсан улс төрийн хэлмэгдүүлэлтийн оргил шатны эхлэл болсон 1937 оны 9 дүгээр сарын 10-ны шөнийн өргөн баривчилгааны дараа тус яамны гүйцэтгэх ажилтнуудыг хуралдуулан "хувьсгалын эсэргүү" хэрэгт баривчлагсдын хэргийг илрүүлэхийн тулд байцаалтыг мөн хатуу чанга явуулах даалгавар өгчээ. Тэрээр "байцаахдаа эрс хатуу байцаах хэрэгтэй. Сайн өдөр, шөнөгүй ажилла. Хоол ундаар зөвхөн ажиллаж байгаа нөхдийг дүүрэн хангах хэрэгтэй. Үүнийг тушаал болгон хэлье"<sup>4</sup> гэжээ. Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийн (ЭБШХ) шаардлагыг ноцтой зөрчиж байцаалтын явцад зөвхөн ДЯЯ-ны дээрхи тушаалын "хатуу чанга байх" гэсэн заалтыг хууль мэт үг дуугүй дагаж мөрдөх болжээ. Эл "хатуу чанга байх" гэсэн заалтын агуулгыг юу гэж ойлгож, болит амьдралд хэрхэн хэрэглэж байсныг 1937-1940 онд ДДЯ- д ажиллаж байсан хүмүүсийн гаргасан тодорхойлолт харуулдаг бөгөөд тэдгээрт "...мөрдөн байцаалт явуулахдаа аль нэгэн хүнийг хэрэг хүлээлтэл нь амралтгүй жижүүрлэн байцаах буюу суусан сандал дээрээ хөдлөх эрхийг хасаж, холбогдох материалын дагуу мэдүүлгийг нь тулган хөтөлж гаргуулах зэрэг аргыг өргөн хэрэглэх болсон... Жишээ нь хэрэг хүлээх хүртэл нь унтах нойр, идэх хоолгүй, уух унд өгөлгүй жижүүрлэн байцаах, халуун пийшингийн дэргэд өндөр хөлтэй нарийхан сандал дээр хөдөлгөхгүй суулган байцаалт явуулдаг байсан. Үүнээс болж байцаагдаж байгаа хүмүүс арга буюу хэрэг хүлээж мэдүүлэг өгдөг байсан".<sup>5</sup> "Мөрдөн байцаалт хуулиас гадуур завхралтай явагдаж байснаас хэрэг хүлээх нь хялбархан байсан. Учир нь жижүүрлэж, хоолыг нь хасаж, нойргүй суулгаж байцаах, зодох, буу түлгэж сүрдүүлэх, карцерт 2-3 хоногоор хорьж ядраан мөрдөж байсан. Өндөр сандалд суулгаж зовоох, чи хэлсэн ч, хэлээгүй ч, чиний хэрэг чинь бэлэн болсон гэж тулгадаг байснаас үндэслэн хүмүүс худал мэдүүлэг гаргаж хэрэг хүлээдэг болсон юм. Тэрч байтугай тэр үед хэрэгтнийг байцаагаад хэрэг хүлээхгүй болохоор нь хэлтэс, тасгийн дарга нарт илтгэхэд ялыг нь төлөвлөж ир гэж нэр нь онгорхой, бичгийн машинаар цохисон ялын төлөвлөгөөнүүдийг бидэнд өгч гаргадаг байсан. Энэ ёсоор биеийн байцаалтыг нь авч, тэр онгорхой асуултуудыг нь таглаж ялын төлөвлөгөө болгон хэлтсийн даргад өгдөг байсан. Хэрэгтэн гарын үсэг зурахгүй бол хүчээр эрхий хуруугий нь хүртэл даруулж хэрэг хүлээсэн болгодог байсан."<sup>6</sup> гэжээ

МАХН-ын Төв Хорооны 1937 оны 10 дугаар сарын 22-26-нд хуралдсан III Бүгд хурлын тогтоолд "Удаа дараагийн хувьсгалын эсэргүү байгууллагуудыг илрүүлэн олж чадсан ба мөн Гэндэн, Дэмид нарын зэрэг эх орноосоо урвасан зандалчинг/удыг илрүүлэн олсон явдал бол гагцхүү Дотоод Явдлын Яам ба түүний харъяа газруудын сэрэмж анхаарлын ач үр ба гавъяа мөн байна" хэмээн тэмдэглээд "Урван тэрслэж, хорлон сүйтгэгчидтэй хайр найргүй тэмцэхээр үл барам, улсын ба ардын хөрөнгийг бүрэлгэн үрэгдүүлэгчдийн хэргийг хууль ёсоор түргэн цагийн дотор таслан шийтгэж гэмт этгээдийг Японы ба фашист нарын шууд туслагч гэж үзэж эдгээр хорт явдлуудыг цаашид үргэлжийн бөгөөд хайр гамгүйгээр тэмцэж байхыг Шүүх ба Дотоод Явдлын Яаманд даалгасугай" гэж заажээ.

<sup>4</sup> Тагнуулын төв газрын архив. 1937 оны тушаал..., 1-14-т., 1-4-1-ийн 58-т

<sup>5</sup> Думбарай.А, Тамлан тарчлаагчдын өчиг., Улаанбаатар., 1994, 9дэх

<sup>6</sup> Мөн тэнд

Монгол улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын (ЦАУЗБУК) албан ёсны тоо баримтаар (2005 оны 12 сарын байдлаар) улс төрийн хэлмэгдүүлэлтэд 29 мянган хүн цагаатгагдснаас цаазаар авахуулсан 19411 хүнийг цагаатгасан байна. Гэтэл зөвхөн онцгой бүрэн эрхт комисс 1937 оны 9 сараас 1939 оны 4 сар хүртэл ажиллах хугацаандаа 50 удаа хуралдаж 20474 хүнийг буудан алахаар шийдвэрлэж байсан баримт бий.<sup>7</sup> Эдгээр нь төрөөс өөрийн иргэддээ хэрхэн хандаж, бөөнөөр нь алан хядах явдлыг төрийн ямар ч хяналтгүйгээр үйлдэж, гэм буруугүй олон хүний амьд явах эрхийг хөсөрдүүлж байсныг шууд нотлон харуулж байна. Шүүхээс тавих хяналтын оронд цаазаар авах ял хэрэглэж байгааг намын дээд удирдлагын хэдхэн цөөн тооны эрх мэдэлтэн хянаж үзсэн болдог байжээ. Ийнхүү Монгол улсад ямар ч гэм буруугүй олон мянган иргэнд цаазаар авах ялыг шүүхийн бус байгууллага ногдуулж байсан түүхэн аймшигтай хэрэг явдал гарч байжээ. Энэ нь цаазаар авах ялыг олон нийтийн онцгой анхаарлын төвд тэдний байнгын хяналтад байлгаж, олон улсын стандартын шаардлагыг дагаж мөрдөхийн зайлшгүйг харуулж байна.

### **2.3 Монгол улсын дагаж мөрдөж буй 2002 оны Эрүүгийн хууль дахь цаазаар авах ялын байдал**

Монгол Улсын Их Хурал 2002 онд шинэ Эрүүгийн хууль баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдүүлж байна. Тус Эрүүгийн хуулиар дараахи төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр тогтоосон байна: төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах (81.2 дугаар зүйл); хорлон сүйтгэх (84 дүгээр зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (91.2 дугаар зүйл); онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (126.3 дугаар зүйл) зандачлах (177.2 дугаар зүйл); төрлөөр устгах (302 дугаар зүйл) Мөн хуулийн 53.4 дүгээр зүйлд “Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй” хэмээн заасан байна.

2002 оны Эрүүгийн хуулийн хорлон сүйтгэх (84 дүгээр зүйл) гэмт хэрэгт үйлдвэр, байгууламж, зам харилцаа, холбооны хэрэгсэл, бусад эд хөрөнгийг тэслэх, дэлбэлэх, галдан шатаах болон бусад аргаар хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан, хүн мал, ургамлын гоц халдварт өвчин тараасан зэрэг хүний амь нас зориуд бусниулаагүй үйлдэлд цаазаар авах ял ногдуулах боломжтой байгаа юм. Өмнөх Эрүүгийн хуульд бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтай санаатай алсан 14 үндэслэлийг жагсааж цаазаар авах ял тогтоож байсан бол 2002 оны Эрүүгийн хуулиар эл жагсаалт 17 болж гурваар нэмэгдүүлсэн байна. Онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (126.3 дугаар зүйл) гэмт хэрэгт эл гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, өөр хүнд хор уршиг учирсан, бага насны хүүхэд хүчиндсэн зэрэг хүний амь нас хохируулаагүй таван тохиолдолд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Зандачлах “терроризм үйлдэх” (177.2 дугаар зүйл) гэмт хэрэгт эл гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, өөр хүнд хор уршиг учирсан зэрэг хүний амь нас хохируулаагүй дөрвөн тохиолдолд цаазаар авах ял тогтоосон байна. Төрлөөр устгах (302 дугаар зүйл) бие махбодид хүнд гэмтэл учруулсан, төрөлтийг хүчээр зогсоосон, хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан зэрэг хүн амь нас бусниулаагүй дөрвөн үйлдэлд цаазаар авах ял хэрэглэхээр заажээ. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын

<sup>7</sup> Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал., Улаанбаатар., 2000, 170дахь талд

## Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял

дүрэмд төрлөөр устгах гэмт хэрэгт цаазаар авах ял тогтоогоогүй бол Монгол улсын 2002 оны Эрүүгийн хуулиар цаазаар авах ял заасан байна. Ийнхүү Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийг өмнөх хуультай (1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуультай) харьцуулахад цаазаар авах ялыг хэрэглэх хүрээг үлэмж өргөжүүлсэн байна.

### 2.4 Цаазаар авах ял ба Монголын шүүхийн практик

Монголын шүүхийн практикт судалгаа хийж үзэхэд цаазаар авах ялыг зөвхөн бусдыг хүндрүүлэн үзэх нөхцөл байдалтайгаар санаатай алсан гэмт хэрэгт шүүхүүд ногдуулж иржээ. Тус судалгааны явцад 1965 оноос хойш буюу сүүлийн 40 жилд Монголын шүүх цаазаар авах ялыг хэрэглэж ирсэн статистикийг дараахи байдлаар тоймлон харуулж болохоор байна.

#### Монгол улсад цаазаар авах ялыг шүүхээс сүүлийн 40 жилд ногдуулсан байдалд хийсэн судалгаа (1965-2005)

| Он   | Нийт | Өсөлт/ бууралтын харьцуулалтын хувь ( % ) |            |
|------|------|---|------------|
|      |      | өмнөх жилтэй                              | 1965 онтой |
| 1965 | 7    |   |            |
| 1966 | 12   | +71.4%                                    | +71.4%     |
| 1967 | 8    | -33.3%                                    | +14.2%     |
| 1968 | 10   | +25%                                      | +42.8%     |
| 1969 | 10   | 0%  | +42.8%     |
| 1970 | 4    | -60%                                      | -57.1%     |
| 1971 | 8    | + 100%                                    | + 14.2%    |
| 1972 | 5    | -37.5%                                    | -28.5%     |
| 1973 | 8    | +37.5%                                    | +14.2%     |
| 1974 | 10   | +25%                                      | +42.8%     |
| 1975 | 13   | +30%                                      | +85.7%     |
| 1976 | 12   | -7.6%                                     | +71.4%     |
| 1977 | 12   | 0%  | +71.4%     |
| 1978 | 14   | +12.6%                                    | + 100%     |
| 1979 | 26   | +85.7%                                    | +271.4%    |
| 1980 | 19   | -26.9%                                    | + 171.4%   |
| 1981 | 18   | -5.2%                                     | + 157.1%   |
| 1982 | 17   | -5.5%                                     | + 142.8%   |
| 1983 | 13   | -23.5%                                    | +85.7%     |
| 1984 | 17   | +23.5%                                    | + 142.8%   |
| 1985 | 27   | +58.8%                                    | +285.7%    |
| 1986 | 19   | +29.6%                                    | + 171.4%   |
| 1987 | 14   | -26.3%                                    | + 100%     |
| 1988 | 13   | -7.1%                                     | +85.7%     |
| 1989 | 14   | +7.1%                                     | + 100%     |
| 1990 | 15   | +7.1%                                     | + 114.2%   |
| 1991 | 21   | +40%                                      | +200%      |

Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял

|      |    |         |          |
|------|----|---------|----------|
| 1992 | 34 | +61.9%  | +385.7%  |
| 1993 | 28 | -17.6%  | +300%    |
| 1994 | 30 | +7.1%   | +328.5%  |
| 1995 | 32 | +6.6%   | +357.1%  |
| 1996 | 21 | -34.3%  | +200%    |
| 1997 | 24 | + 14.2% | +242.8%  |
| 1998 | 17 | -29.1%  | + 142.8% |
| 1999 | 24 | +29.1%  | +242.8%  |
| 2000 | 13 | -45.8%  | +85.7%   |
| 2001 | 24 | +45.8%  | +242.8%  |
| 2002 | 18 | 25%     | + 157.1% |
| 2003 | 22 | +22.2%  | +214.2%  |
| 2004 | 22 | 0%      | +214.2%  |
| 2005 | 31 | +29%    | +342.8%  |

Монгол улсад цаазаар авах ял шийтгүүлэгчдийн тоог албан ёсоор хэвлэн гаргахыг зөвшөөрдөггүй. Өмнө дурдсан тоо баримт анх удаа хэвлэгдэж байгаа бөгөөд албан ёсны эх сурвалжаас авсан болно.

Сүүлийн 40 жилийн энэхүү тоо баримтаас үзэхэд шүүх 806 хүнд цаазаар авах ял ногдуулсан байна. Шүүхээс цаазаар авах ял ногдуулах явдлын өсөлт, бууралтад дагаж мөрдөж буй эрүүгийн хууль, тус улсад үйлдэгдэж буй гэмт явдлын шинж буюу онц хүнд гэмт явдлын гаралт, улс орны нийгэм, эдийн засагт гарсан эрс өөрчлөлт, тухайн цаг үеийн шүүхийн ялын бодлого, хүмүүсийн амьдралын түвшин, нийгмийн сэтгэл зүйн байдал гэх зэрэг хүчин зүйлс шууд нөлөөлдөг болох нь тодорхой байна. Тухайлбал, тухайн цаг үеийн шүүхийн ялын бодлого цаазаар авах ялд хэрхэн нөлөөлдгийг ганцхан жишээгээр харуулахад 1984 онд МАХН-ын Төв Хорооноос хуулийн байгууллагуудад хууль ёс ноцтой зөрчигдөж байгаа талаар авах зарим арга хэмжээний талаар тогтоол гаргаж, улмаар ялын бодлогыг чангатгах чиглэлийг хуулийн байгууллагын удирдлагад өгч байжээ. Үүнээс шууд шалтгаалан 1985 онд цаазаар авах ял шийтгүүлэгсдийн тоо 1965 онтой харьцуулахад 285,7 хувиар, өмнөх онтой харьцуулахад 58,8 хувиар гэнэт огцом өсөх хандлагаа ажиглагдаж байжээ.

1990-ээд оны үед Монгол улс нийгмийн эрс өөр тогтолцоонд шилжилт хийсэн онцлог нөхцөл байдлын үед 1991-1995 онд шүүхээс цаазаар авах ялаар шийтгүүлэгсдийн тоо үлэмжхэн өссөн статистик анхаарлыг зүй ёсоор татсаар байна.

**Хууль тогтоогчид 2002 оны Эрүүгийн хуулийн ялын бодлогыг маш хатуу чанга болгосноор шүүхээс цаазаар авах ял хэрэглэх байдал өмнөх үетэй харьцуулахад үлэмж нэмэгдсэн байна** Тухайлбал, 2003-2005 онд өмнөх онтой харьцуулахад цаазаар авах ялаар шийтгүүлэгсдийн тоо 20 гаруй хувиар тогтвортой өсөх хандлага ажиглагдаж байна.

2000 онд шүүх 13 хүнд цаазаар авах ял ногдуулснаас Улсын Дээд шүүхийн давж заалдах шатны тэдгээр шийтгэх тогтоолуудаас 3-ыг өөрчилж, 2-ыг хүчингүй болгож байжээ.<sup>8</sup> Энэ бол ихээхэн ноцтой баримт юм. Өөрөөр хэлбэл нэг жилд шүүхээс цаазаар авах ял ногдуулсан тогтоолын 30 шахам хувь нь зөвхөн давж заалдах шатны шүүхээр өөрчлөгдснөөс 10 шахам хувь нь хүчингүй болсон буюу өөрөөр хэлбэл цаазаар авах ялыг шүүх гэм буруугүй хүнд ногдуулж байсан гэсэн хэрэг юм.

<sup>8</sup> (Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал.2001..., Улаанбаатар., 76 дахь талаас үз.)

## *Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял*

Цаазаар авах ялыг гэм буруу нь хөдөлбөргүй шууд нотлогдон тогтоогдоогүй буюу гэм буруугүй хүмүүст шүүх ногдуулж, тэр нь их үнэ цэнээр засагдаж байсан тодорхой баримт сүүлийн 20 жилд нэг бус удаа гарч байжээ. Жишээлбэл, 1980-аад оны сүүлчээр “Д” гэгчийг алсан хэрэгт буруутган хууль бусаар тодорхой хүмүүст шүүх цаазаар авах ял ногдуулж байсан нь тогтоогдсон. Саявтархан иргэн “Э”-д Завхан аймгийн шүүх бусдыг санаатай алсан хэрэгт гурван удаа цаазаар авах ял ногдуулж, дээд шатны шүүх тухай бүрд нь хэргийн бүрдэл хангагдаагүй, шүүгдэгчийн гэм буруу нь тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр цаазаар авах ял ногдуулсан шийтгэх тогтоолыг хүчингүй болгож байсан юм.<sup>9</sup> Цаазаар авах ял бол хэрэв алдаа гаргавал засарч залруулахын аргагүй байдалд оруулдаг хамгийн эрсдэл ихтэй ял мөн. Бидний үзэж байгаагаар Монгол улсад цаазаар авах ял ногдуулах үед шүүхээс гаргах алдаа барагцаалбал 30 гаруй хувьтай байх магадлалтай байна.

<sup>9</sup> Мөн тэнд үз



## 1. Цаазаар авах ялтай хэргийн Монгол улс дахь шүүн таслах ажиллагаа

### 1.1 Цаазаар авах ялтай хэргийн мөрдөн байцаалт

Монгол улсын Эрүүгийн хуулиар цаазаар авах ял ногдуулж болох гэмт хэрэг нь онц хүнд гэмт хэргийн ангилалд хамаарагддаг. Тийм учраас ийм гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа заавал явагддаг. Харин Монгол улсын Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулиар (цаашид ЭБШХ гэнэ) хөнгөн буюу хөнгөвтөр гэмт хэргийн ангилалд багтаж буй гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа хийж прокурорт шилжүүлдэг онцлогтой.

ЭБШХ-ийн 27 дугаар зүйлд заасны дагуу мөрдөн байцаалтыг Тагнуулын Ерөнхий газрын мөрдөн байцаагч, Мөрдөн байцаах байгууллагын мөрдөн байцаагч явуулна. Тагнуулын Ерөнхий газрын мөрдөн байцаагч нь төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах (81.2 дугаар зүйл); хорлон сүйтгэх (84 дүгээр зүйл); төрлөөр устгах (302 дугаар зүйл), Мөрдөн байцаах байгууллагын мөрдөн байцаагч нь хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (91.2 дугаар зүйл); онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (126.3 дугаар зүйл), зандачлах (177.2 дугаар зүйл) гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулна.

Цаазаар авах ял ногдуулж болох гэмт хэрэгт ЭБШХ-д заасны дагуу ердийн журмаар эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулна. Мөрдөн байцаалт явуулах үндсэн хугацаа нь эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 2 сар байхаар хуульд заасан. Эл хугацааг ЭБШХ-ийн 182 дугаар зүйлийн 4-т заасны дагуу сунгаж болох бөгөөд хэрэгт хяналт тавьж буй прокурор 2 сар хүртэл, сум буюу сум дундын, дүүргийн ахлах прокурор, дагнасан прокурорын орлогч 5 сар хүртэл, аймаг нийслэлийн болон дагнасан прокурор 9 сар хүртэл, Улсын ерөнхий прокурорын туслах, орлогч тус бүр 3 сар хүртэл хугацаагаар сунгана. Хэргийн мөрдөн байцаалтын хугацааг цаашид сунгах асуудлыг Улсын ерөнхий прокурор шийдвэрлэнэ. Мөрдөн байцаах ажлын өнөөгийн практикийг судлахад цаазаар авах ялтай хэрэгт мөрдөн байцаалтын хугацааг сунгах явдал ердийн үзэгдэл болсон байх бөгөөд олон жил, сараар үргэлжлэн сунжрах, нэмэлт мөрдөн байцаалтад буцах явдал олонтоо ажиглагдсан.

**Судалгааны явцад ажиглагдсан өөр нэг ноцтой асуудал бол хэргийн газрын үзлэгийг хангалтгүй явуулсан, шууд нотлох баримт олж тогтоож чадаагүй, мөрдөн байцаалтын ажиллагааг дутуу хийж, хэргийн талаар нотолбол зохих байдлуудыг шалгаж тогтоогоогүй, нэг талыг хэт барьсан, хууль бус арга замаар сэжигтэн, яллагдагчаар хэрэг хүлээлгэсэн, эрүү шүүлт тулгасан, харгис хэрцгий арга хэрэглэсэн, өмгөөлөгчгүйгээр байцаасан явдал цөөнгүй гарч байгаа явдал юм.**

Мөрдөн байцаалтын хугацаа нь мөрдөн байцаагч яллагдагчид яллах дүгнэлт үйлдүүлэх саналыг прокурорт тавьснаар, эсвэл хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргаснаар дуусгавар болдог.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурор хяналт тавьж оролцоно. Мөрдөн байцаалт дууссан хэргийн талаар прокурор 14 хоногт ЭБШХ-ийн 214 дүгээр зүйлд заасны дагуу хянавал зохих зүйлүүдийг хянаад хэргийн бүрдэл хангагдсан, хэргийг шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой гэж үзвэл яллах дүгнэлт үйлдэн, хэргийг харъяаллын дагуу шүүхэд шилжүүлнэ. Шүүхэд ирснээс хойш 15 хоногийн дотор шүүгч яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж үйлдэнэ. Яллагдагчийг шүүхэд

шилжүүлэх тухай шүүгмийн захирамж гаргасан өдрөөс эхлэн 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхэлнэ.

## **2.1 Цаазаар авах ялтай хэргийн шүүх хуралдаан**

Сум буюу сум дундын, дүүргийн шүүх цаазаар авах ялтай хэргийг анхан шатны журмаар нэг бус харин 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг онцлогтой. Шүүх хуралдаан эрх тэгш бүхий яллах ба өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана хэмээн хуульд заажээ.

Шүүгдэгчид сонсгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээнэ.

Цаазаар авах ялаар шийтгэгдэж болох гэмт хэргийн мөрдөн байцаалт ба шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулахаар ЭБШХ-ийн 40.1.4-т заасан байна. Цаазаар авах ялтай хэрэгт мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах үүргийг хуулиар хүлээсэн байдаг. Гэвч судалгаанаас үзэхэд Цагдан хорих байруудад сэжигтэн, яллагдагчдыг өмгөөлөгчөөр хангах сонирхол тэр болгон байдаггүй. Яагаад гэвэл цагдаагийнхан хэрэг хүлээх гэж байсан хүн больчихдог, өмгөөлөгч “үг зааж өгдөг” хэмээн үздэг. Цаазаар авах ял шийтгэсэн анхан шатны шүүхийн тогтоол хүчингүй болж байгаа нэг гол шалтгаан бол өмгөөлөгчөөр хангаагүй явдал болж байна.<sup>10</sup>

Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалахаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг нээлттэй явуулна. Гэвч урьдчилан хорих байранд шүүх хуралдааныг хийх явдал цөөнгүй гарч байгаа нь өнгөцхөн харахад шүүх хуралдааныг нээлттэй явуулж байгаа мэт санагдуулдаг боловч хэрэг дээрээ хаалттай болгодог. Энэ нь шүүхийг алдаа гаргахад хүргэж болзошгүй нэгэн зүйл болно. Хэрэв хуульд заасан үндэслэлээр шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.

Цаазаар авах ял ногдуулж болох гэмт хэрэг нь Монгол улсын эрүүгийн хуулиар онц хүнд гэмт хэргийн ангилалд багтдаг учраас анхан шатны шүүх хуралдаанд 3 иргэдийн төлөөлөгчийг оролцуулна. Иргэдийн төлөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавих, нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруу, түүнд ногдуулах ялын талаар саналаа бичгээр гаргах эрхтэй байдаг. Иргэдийн төлөөлөгчид санал зөрөлдсөн тохиолдолд саналаа тус тусдаа гаргаж болдог.

## **2.2 Цаазаар авах ялыг давж заалдах эрх**

Цаазаар авэх ял ногдуулсан анхан шатны шүүхийн тогтоолд ялтан түүний төлөөлөгч давж заалдах гомдол гаргах эрх эдэлнэ. Уг ялтан анхан шатны шүүхийн тогтоолыг гардаж авсан буюу түүнийг танилцуулснаас хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдлыг аймаг, нийслэлийн шүүхэд гаргана. Давж заалдах шатны шүүх гомдолтой хэргийг хүлээж авсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан хэлэлцэнэ. Давж заалдах шатанд хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа өмнө дурдсан 3 шүүгчийн нэг нь хэргийн талаар илтгэх бөгөөд хэргийн агуулга, гомдлын үндэслэлийг дурдах байдлаар илтгэнэ. Дараа нь давж заалдагч гомдлоо тайлбарлах бөгөөд шүүх нотлох баримтыг шинжлэн судлах, хуралдаанд оролцогчийн тайлбарыг сонсох, улмаар прокурорын дүгнэлт, шийтгэгдсэн этгээд, түүний өмгөөлөгчийн нэмэлт тайлбарыг сонсоно. Ажиглалт судалгаанаас үзэхэд

<sup>10</sup> 2005 онд эрүүгийн шүүн таслах ажиллагаанд гарсан алдаа зөрчлийг судалсан тухай тойм-Монгол улсын Дээд шүүхийн мэдээлэл, 2006., 002 79, 34 дэхь талыг үзнэ үү.

цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийг давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцуулахгүй байгаа нь түүний эрхийг ноцтой зөрчиж буй явдал гэж үзэхээс өөр аргагүй байдалд хүргэж байна. Ийм хуралдаанд зөвхөн прокурор, өмгөөлөгч зэргийн тайлбарыг сонсдог буруу практик хэвшил болон тогтжээ.

Давж заалдах шатны шүүх магадлал гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орж, дараахи шийдвэрийн аль нэгийг гаргана: Үүнд

- давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож, тогтоолыг хэвээр үлдээх
- тогтоолыг хүчингүй болгож, хэргийг мөрдөн байцаалтад буюу анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаах
- тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох
- тогтоолд өөрчлөлт оруулах. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг уншиж сонсгомогц нэн даруй заавал биелүүлнэ.

Ялтан, түүний өмгөөлөгч анхан шатны болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл хяналтын шатны буюу Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрх эдэлдэг. Хяналтын шатны шүүхэд гаргаж байгаа гомдлыг тогтоол, магадлал гаргасан шүүхээр дамжуулан гаргана. Шүүх хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх ба хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан энэ хугацааг Улсын Дээд шүүхийн танхимийн тэргүүн шүүгч 14 хоногийн хугацаагаар сунгаж болдог. Хяналтын журмаар хэргийг 5 шүүгчийн бүрэлдүүнтэйгээр хянан шийдвэрлэж, тогтоол гаргах бөгөөд энэ нь эцсийн шийдвэр байна. Хяналтын шатны шүүх дараахи шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- тогтоол, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хэрэгсэхгүй болгох
- тогтоол, магадлалд өөрчлөлт оруулах
- тогтоол, магадлалыг хүчингүй болгож, мөрдөн байцаалт, шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах

ЭБШХ-ийн 356 дугаар зүйлд заасны дагуу цаазаар авах ял шийтгүүлсэн хэргийг хяналтын журмаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр гомдол гаргасныг харгалзахгүйгээр хянан хэлэлцэнэ. Ийнхүү цаазаар авах ял ногдуулсан шүүхийн тогтоолыг давж заалдах шатанд хянагдсан эсэхээс үл хамаарч, заавал Улсын дээд шүүхийн хяналтын шатаар хянах журмыг 1993 оноос эхлэн тогтоосон нь Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын “Энэхүү шийтгэлийг гагцхүү эрх бүхий шүүхээс гаргасан таслан шийдвэрлэх эцсийн тогтоолыг биелүүлэх замаар хэрэгжүүлж болно” гэсэн заалттай нийцэж байгаа юм Улсын дээд шүүх буюу хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн тогтоолыг хэвээр баталсан бол ялтан өөрт үлдэх сүүлчийн боломжоо ашиглан Монгол улсын ерөнхийлөгчид хандан уучлал хүснэ.

### **2.3 Цаазаар авах ялын талаархи уучлалт**

“Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр ял хэлтрүүлэх хүсэлт гаргах эрхтэй. Бүх тохиолдолд ял хэлтрүүлж, өршөөл уучлал үзүүлж, цаазаар авах ялыг өөрчилж болно.” гэж Монгол улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлийн 4-т заасан билээ.

Монгол улсын үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1.8-д зааснаар ялтанд уучлал үзүүлэх нь Монгол улсын ерөнхийлөгчийн бүрэн эрх болохыг хуульчилсан бөгөөд уучлал үзүүлсэн тохиолдолд Ерөнхийлөгч зарлиг гаргана. Монгол улсын эрүүгийн хуулийн 53.3-т “Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол улсын Ерөнхийлөгчид



хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд 30 жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино” гэж заажээ.

Цаазаар авах ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар баталсан бол уг шийтгэх тогтоолыг ялтанд 10 хоногийн дотор мэдэгдэж, ийнхүү мэдэгдснээс хойш 15 хоногийн дотор анхан шатны шүүх ялтан амь уучлахыг хүссэн өргөдөл гаргах эсэхийг тодруулж, хэрэв гаргавал түүнийг, хүсэлтгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэж Улсын дээд шүүхэд ирүүлэх журам үйлчилж байна.

Улсын дээд шүүх өргөдөл буюу тэмдэглэлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор материалыг хэргийн хамт Монгол улсын Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Монгол улсын Ерөнхийлөгч хэргийг хүлээн авснаас хойш 30, зайлшгүй шаардлагатай бол 60 хоногийн дотор ялтанд уучлал үзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Уучлалын асуудлыг шийдвэрлэх хүртэл цаазаар авах ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэхийг түдгэлзүүлнэ.

Цаазаар авах ял шийтгүүлсэн ялтанд уучлал үзүүлэх явдлыг “Ялтанд уучлал үзүүлэхийг хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх журам”-аар зохицуулж байгаа бөгөөд эл журмыг Ерөнхийлөгчийн 2002 оны 156 дугаар зарлигаар баталсан, эл зарлиг нь төрийн нууцын зэрэглэлд хамаарч байна.

Цаазаар авах ял шийтгүүлсэн ялтанд уучлал үзүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ дор дурдсан зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

- үйлдсэн хэргийн улмаас учирсан нийгмийн хор аюулын хэмжээ, хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөлүүд;

- уучлалт үзүүлэхийг хүсэж байгаа шалтгаан;

-урьд нь хууль, зарлиг, шүүхийн шийдвэрээр ялаас чөлөөлж байсан зэрэг болно.

Уучлал үзүүлэхэд ялтны уучлалт хүссэн өргөдлийг гэр бүлийн санал, эсхүл эцэг эхийн оршин байгаа сум, хорооны Засаг дарга, ял эдэлж байгаа хорих ангийн дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг авна.

Ялтанд уучлал үзүүлэхийг хүссэн өргөдлийг Ерөнхийлөгчийн тамгын газрын хариуцсан референт судалж, саналаа Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөхөд танилцуулах бөгөөд уучлал үзүүлэх үндэслэлтэй гэж үзвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас уг ялтны талаар санал, дүгнэлт, дэлгэрэнгүй судалгаа, шаардлагатай нэмэлт материалыг гаргуулж авна. Холбогдох санал, дүгнэлт, материалыг авсны үндсэн дээр уучлалын асуудал хариуцсан референт танилцуулга бичиж, Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх, референт нар гарын үсэг зурж, зарлигийн төслийн хамт Ерөнхийлөгчийн тамгын газрын даргад танилцуулна. Ялтанд уучлал үзүүлэх тухай саналыг тамгын газрын дарга зөвшөөрч, зарлигийн төсөлд гарын үсэг зурсны дараа хуулийн бодлогын зөвлөх уг асуудлыг Ерөнхийлөгчид танилцуулан шийдвэрлүүлнэ.

Уучлал үзүүлэх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг ажпын 8 цагт багтаан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргүүлнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар уучлал үзүүлэх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг хүлээн аваад, Ерөнхийлөгчийн зарлигийг ялтанд танилцуулж, цаашид төрийн хууль тогтоомжийг чанд сахиж, дахин гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх тухай амлалтыг бичгээр гаргуулж, Ерөнхийлөгчийн тамгын газарт ирүүлэх ёстой байдаг.

Уучлал үзүүлсэн эсэх тухай хариуг прокуророор дамжуулан өгнө.

## 2.4 Цаазаар авах ялын хүлээлт

Судалгаанаас үзэхэд цаазаар авах ялаар шийтгүүлсэн этгээд шүүхийн давж заалдах ба хяналтын шат, Улсын дээд шүүхийн бүх гишүүдийн хуралдаан дараа нь Ерөнхийлөгчөөс уучлал хүсэх, тэрчлэн цаазаар авах ял гүйцэтгэх зэргээр цаг хугацааны ба санаа сэтгэлийн хүнд хүлээлтийг даван туулах шаардлагатай болдог байна. Цаазаар авах ялаар шийтгүүлсэн ялтныг байлгах нөхцөл журам, тэдний эрх зүйн байдлын эрх зүйн эх сурвалж нь 1999 оны Сэжигтэн, яллагдагч, баривчлагдсыг цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай Монгол улсын хууль, 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай Монгол улсын хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2005 оны 14 тоот тушаал зэрэг юм.

*Цаазаар авах ял шийтгүүлсэн ялтныг хорих байрны нөхцөл* Өнөөгийн нөхцөлд цаазаар авах ялаар шийтгүүлсэн ялтныг хорих нөхцөл нь дараахи байдалтай байгаа болно.

- Харуул хамгаалалтанд хамгийн ойрхон тусгай камерт хорьж байна;
- Эргүүл жижүүрийн ажилтнууд камерийн цоожийг ганц нэгээрээ онгойлгохгүй байх журамтай;
- Хорих өрөө нь төмөр хаалгатай, онгойлгох хязгаарлагчтай, хяналтын шагайвчтай, гадна талдаа цоожтой, цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, агааржуулах салхивчтай, модон шалтай, эсвэл модон наартай байдаг;
- Хорих өрөөний чийглэг нь 55-60 хувь, өвлийн улиралд 18 хэмээс багагүй дулаантай байх ёстой. Гэвч судалгаанаас үзэхэд салхивч муутай, халуун хүйтэн, чийгшилт заасан хэмжээнд хүрдэггүй, хорих өрөөний нөхцөл муу гэсэн шаардлага, мэдэгдлийг прокурорын шалгалтын дүнд байнга өгсөөр иржээ;
- Хорих өрөө нь байнгын камерийн хяналттай;
- Цаазаар авах ялаар шийтгүүлсэн ялтны гар, бас хөлд нь байнга гав хэрэглэнэ;
- Хорих өрөө нь 2.5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байна;
- Хорих байрны дотоод журмын дагуу 7 хоногт 2-оос доошгүй удаа 30 минутаас багагүй хугацаанд салхинд гаргана;
- Цаазаар авах ял шийтгүүлсэн хүнийг онц аюултай гэмт хэрэгтэнд тооцож бусад сэжигтэн, яллагдагч, баривчлагдсан хүмүүсээс тусгаарлан хорьдог. *Судалгаанаас үзэхэд цаазаар авах ялаар шийтгүүлсэн этгээдтэй хүний ёсноос гадуур харьцах явдал түгээмэл хандлага болжээ.*

### **Цаазаар авах ял шийтгүүлэгчийн хүлээлтийн үеийн эрх зүйн байдал**

Шүүхийн шийтгэх тогтоолоор цаазаар авах ялаар шийтгүүлсэн шүүгдэгчид шүүхийн тогтоол, магадлал хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө төрөл садангийн хүнтэй нь уулзуулах зөвшөөрлийг прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан тушаалтан олгоно. Төрөл садангийн хүн гэдэгт ЭБШХ-ийн 5.1.14-т заасны дагуу нэг гэр бүлд хамт амьдардаггүй эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, ач, гуч, жич, төрсөн ах, эгч дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхэд юм. Харин ЭБШХ-ийн 331 дүгээр зүйлд заасны дагуу цаазаар авах ял шийтгүүлэгчид давж заалдах шатны хуралдаан дууссаны дараа төрөл, садангийн хүнтэйгээ нэг удаа уулзах боломжийг заасан байна.

Цаазаар авах ял шийтгүүлэгчийг шүүгчийн захирамж болон прокурорын баталсан тогтоолыг үндэслэн ЭБШ хуульд заасан хугацаагаар хорино. Анхан шатны шүүх цаазаар авах ял ногдуулах тухай шийтгэх тогтоолыг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор уг тогтоолын хувийг шийтгүүлсэн этгээдэд гардуулж өгнө. (ЭБШХ-302.1) Шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд түүнийг гардаж

авснаас хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдлыг аймаг, нийслэлийн шүүхэд гаргана. (ЭБШХ-304.1) Давж заалдах шатны шүүх гомдолтой хэргийг хүлээн авсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хянан хэлэлцэнэ. Энд бас хавтаст хэрэг давж заалдах шатны шүүхэд хэд хоногийн хугацаанд очихийг харгалзах ёстой. Хэргийг өмнө дурдсан 30 хоногийн хугацаанд хянан хэлэлцэх боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар 30 хүртэл хоногоор сунгаж болно. Ийнхүү анхан шатны шүүх цаазаар авах ял ногдуулснаас хойш наад зах нь 80 хоногийн дараа давж заалдах шатны шүүхийн шийдвэр гарна. Хэрэв давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шүүхийн тогтоолыг хэвээр баталсан бол ялтан, түүний төлөөлөгч хяналтын буюу Улсын дээд шүүхэд хандана.

Улсын дээд шүүх хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх ба энэ хугацааг 14 хоногоор сунгаж болно. Үүнээс гадна ЭБШХ-ийн 356 дугаар зүйлд заасны дагуу цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн хэргийг хяналтын журмаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр заавал хянан хэлэлцэнэ. Ингэж хэлэлцэх хугацааг хуульд заагаагүй байна. Бидний үзэж байгаагаар наад зах нь олон арван долоо хоногийн хугацаа шаардагдах бөгөөд Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан нэг улиралд маш цөөн хуралддаг байна. Ийнхүү хяналтын болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан дуустал наад зах нь 150 хоног буюу 5 сарын хугацаа шаардагдана. Ийнхүү анхан шатны шүүх цаазаар авах ял ногдуулснаас хойш шүүхийн бүх шат дамжлага дуустал 220 буюу наад зах нь 7 сар гаруй хугацаа өнгөрдөг байна.

Монгол улсын Ерөнхийлөгчид уучлал хүсэх тухай өргөдөл гаргана. Цаазаар авах ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар баталсан бол уг шийтгэх тогтоолыг ялтанд 10 хоногийн дотор мэдэгдэж, ийнхүү мэдэгдснээс хойш 15 хоногийн дотор анхан шатны шүүх ялтан амь уучлахыг хүссэн өргөдөл гаргах эсэхийг тодруулж, хэрэв гаргавал түүнийг, хүсэлтгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэж Улсын дээд шүүхэд ирүүлнэ. Улсын дээд шүүх өргөдөл буюу тэмдэглэлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор материалыг хэргийн хамт Монгол улсын Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Монгол улсын Ерөнхийлөгч хэргийг хүлээн авснаас хойш 30, зайлшгүй шаардлагатай бол 60 хоногийн дотор ялтанд уучлал үзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Эдгээрээс үзэхэд уучлалын өргөдлийг хянан шийдвэрлэхэд наад зах нь 90 орчим хоног шаардагдана. Ийнхүү цаазаар авах ялаар шийтгүүлснээс хойш хамгийн түргэн шуурхай л гэхэд Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эсэхийг шийдвэрлэтэл наад зах нь нэг жилээс доошгүй хугацаа шаардагдаж байгаа бөгөөд энэ цаг хугацаа ялтны сэтгэл санааны хувьд хамгийн их дарамттай, хүнд хэцүү цаг хугацаа байдаг.

## ЭРХ

Цаазаар авах ялаар шийтгүүлсэн этгээд Монгол улсын Ерөнхийлөгчөөс уучлал хүсэх эрх эдэлж, өөрөө болон ар гэр нь Монгол улсын Ерөнхийлөгчөөс уучлал хүссэн бол Ерөнхийлөгчийн шийдвэрийг хүлээнэ.

Цаазаар авах ялтай хэрэгт холбогдсон хүн өмгөөлөгчтэй уулзах, өмгөөлөгч авах, хууль зүйн туслалцаа авах эрх эдэлнэ.

Өөрийн нэр дээрээ захидал, цахилгаан авах эрхтэй боловч хорих байрны захиргаа заавал хянаана.

“Ганц худаг-ийн цагдан хорих төвд сүүлийн 3 жилд хоригдож байгаа цаазаар авах ял шийтгүүлсэн ялтны ял хэргийн байдлаас үзэхэд 2002 оны эрүүгийн хуульд заасан (91-ийн 2) хүнийг санаатай алах онц хүнд гэмт хэрэг үйлдэгчид байгаа болно:

- 2004 онд 12 /үүнээс мөрдөн байцаалтад буцсан 2, ялд нь өөрчлөлт орсон 1/
- 2005 онд 27 (үүнээс мөрдөн байцаалтанд буцсан 9, ялд өөрчлөлт орсон 2, нас барсан 4 - үүнээс 3 нь амиа хорлож нас барсан)
- 2006 оны 1 дүгээр сард шинээр ирсэн 1, ялд нь өөрчлөлт орсон 1, нас барсан 1 (сүрьеэгээр) цаазаар авах ял шийтгүүлсэн ялтан байна.

Баттай эх сурвалжаас үзэхэд сүүлийн жилүүдэд цаазаар авах ялаар шийтгүүлсэн ялтнууд амиа хорлох явдал нэлээд гарч байна. Жишээ нь, 2005 онд нэг камерт байгаа 2 ялтан хамтдаа, 1 ялтан тусдаа амиа хорложээ. Гол шалтгаан нь тэд цогцосоо ар гэрийнхэндээ өгч хүний ёсоор оршуулуулахыг хүссэн гэнэ. Практик амьдрал дээр цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч, баривчлагдсан гэх мэт цагдан хоригдож байгаа хүмүүс өлсгөлөн зарлах нь олонтаа. Тухайлбал, зөвхөн ганц худгийн Цагдан хорих төвд жилдээ 10 гаруй хүн ямар нэг хугацаагаар өлсгөлөн зарладаг байна. Энэ нь юуны өмнө манай улсын хуулийн хорьж мөрдөх хугацаатай холбоотой. Яагаад гэвэл хүнийг дунджаар 24-30 сар хорьдог. Иймд зарим хүн энэ урт хугацааг хүлээхийг тэсвэрлэж чаддаггүйн улмаас өлсгөлөн зарлаж хэргээ хурдан шуурхай, үнэн зөвөөр нь шийдвэрлүүлэхэд тус дөхөм болгохыг ийм замаар оролддог байна. Үнэндээ 2-3 шахам жил цагдан хоригдох нь үнэхээр хүнд хэцүү асуудал болох нь хэн бүхэнд ойлгомжтой. Нөгөө талаар цагдан хоригдож байгаа хүмүүс болон прокурорын хяналтаар хорих ангиудад ял эдэлж байгаа хүнээс орон нутгийн цагдан хорих байруудад ял эдэлж байгаа хүний эрүүл ахуй, нөхцөл байдал нэн доогуур гэж үздэг. Яагаад гэвэл эдгээр Цагдан хорих байруудын ихэнх нь газар дор, цонх нь газар дор байрлалтай, хүйтэн, харанхуй, чийглэг орчинтой аж.

2005-2006 онд Ганц худгийн Цагдан хорих байранд цаазаар авах ялын хүлээлтийн явцад хэд хэдэн хүн амиа хорлосон нь хүлээлтийн хугацаа маш урт, гав, дөнгөтэй удаан байснаасаа залхсан гэж үзэх үндэстэй, нөгөөтэйгүүр цаазаар авах ял гүйцэтгэгдсэн тохиолдолд ар гэрт нь шуурхай мэдээлэл өгдөггүй, төрөл төрөгсдөд нь оршуулах боломж олгодоггүй, хүнийг маш удаан хугацаагаар хорих нь эрүү шүүлт тулгах нэгэн хэлбэр болж байна. Цогцосыг төрөл төрөгсдөд нь өгч хүний ёсоор оршуулах ёс үйлдүүлэх нь монгол хүний хойт насаа боддог уламжлалт сүсэг бишрэлтэй ч холбоотой апуудаг билээ.

Маш урт удаан хугацаагаар хүнийг хорьж цагдаж байгаад зарим хуулийн байгууллага тухайлбал, мөрдөн байцаах байгууллага ба шүүх хуулийн хугацаатай тул байх л ёстой зүйл мэтээр үздэг. Гэтэл амьдралд болохоор тухайлбал “Ганц худаг”-ийн урьдчилан хорих байранд 300 гаруй хоног хоригдоод нүд нь сохорч байжээ.

### 1.1 Цаазаар авах ялын гүйцэтгэл

Монгол улсын эрүүгийн хуульд цаазаар авах ялын гүйцэтгэх хэлбэрийг буудан алах хэмээн заасан. Буудан алах явдлыг гүйцэтгэх журмыг Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталдаг бөгөөд энэхүү зарлигийг төрийн нууцын зэрэглэлд хамааруулсан байна. Энэ учраас цаазаар авах ялыг ямар байгууллага, хэрхэн яаж гүйцэтгэдэг, цогцсыг хэрхэн оршуулдаг, үхснийг иргэний байдлын бүртгэлд хэрхэн тэмдэглэдэг

*Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял*

зэрэг нь тодорхой бус байгаа болно. Монголын өнөөгийн жишээ баримтаас үзэхэд эх хүн цаазлуулсан хүүгээ хаана оршуулсан, түүний булш хаана байгааг асуухад мэдэхгүй гэсэн ганцхан хариулт өгдөг. Тэр эх “Надад цогцсыг нь өгч болохгүй юм уу?, Тэр гэмт хэрэгтэн байсан ч, миний хувьд бол миний л хүү шүү дээ. Би яагаад энэ л миний хүү гэж итгэж үнэмшиж болдоггүй юм бэ?” гэсэн асуултыг байнга тавьдаг. Энэ асуултын цаана төр гэм буруугүй хүмүүс-эх эцэг, эхнэр, хүүхдийн өөрийн ойр дотныхоо хүнийг хүн ёсоор оршуулах боломжийг хязгаарлан тэднийг нэгэн адил залхаан цээрлүүлж байгаа юм биш үү? гэсэн асуудал хариугаа нэхдэг.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## **1. Цаазаар авах ялын дэлхий дахины нийтлэг чиг хандлага**

### ***Цаазаар авах ял ногдуулахыг хориглосон буюу хязгаарласан олон улсын гэрээ***

Дараахи олон улсын гэрээгээр цаазаар авах ял ногдуулахыг хориглосон буюу хязгаарласан байна

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт  
Америкийн хүний эрхийн конвенцийн цаазаар авах ялыг халах тухай протокол  
Европын хүний эрхийн конвенцийн 6 дугаар протокол Европын хүний эрхийн  
конвенцийн 13 дугаар протокол

### ***Цаазаар авах ялын гүйцэтгэлийн байдал***

Өнөөдөр 20,000 гаруй хүмүүс цаазаар авах ялаар шийтгүүлэн хэзээ гүйцэтгэхийг хүлээж байгаа нь Эмнести Интернэшнл байгууллагын судалгаагаар тогтоогдоод байна. Зөвхөн 2005 онд гэхэд л дэлхийн 53 оронд нийт 5,186 иргэнд цаазаар авах ял ногдуулж, түүнээс 22 улс нь хамгийн наад зах нь 2,148 цаазаар авах ялыг гүйцэтгэжээ. Үүний 94 хувийг Хятад, Иран, Саудын Араб, АНУ эзэлж байна. Хятад зэрэг олон засгийн газрууд цаазаар авах ялын гүйцэтгэлийн талаарх албан ёсны статистик тоо баримтыг хэвлэн нийтлэхээс татгалздаг. Вьетнам гэхэд л статистикийн тоо баримтаа ангилан цаазаар авах ял нь “төрийн нууц” хэмээн зарласан байдаг гэх мэтээр цаазаар авах ялын талаарх тоо баримтыг нууцлах нь их байдаг болохоор дээрх тоо баримтыг ойролцоогоор гаргасан гэж үзэж болно.

### ***Цаазаар авах ялыг хязгаарласан болон халсан байдал***

Цаазаар авах ялыг халж байгаа улс орнуудын тоо жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Сүүлийн 20 жилд олон улс гүрэн цаазаар авах ялыг гүйцэтгэхээ хоёр дахин багасгажээ. Дэлхийн улс орнуудын талаас илүү хувь нь цаазаар авах ялыг нэгэнт халсан байна. Үүнийг тоон үзүүлэлтээр гаргавал 86 улсад бүх төрлийн гэмт хэргүүдэд цаазаар авах ял ногдуулахыг цуцалсан байна. Мөн 11 улс дайны үеийн гэмт хэргээс бусад тохиолдолд цаазаар авах ял ногдуулахыг цуцалжээ. Түүнчлэн 25 улс цаазаар авах ялыгхуульдаа тусгасан ч хэрэглэхээ зогсоож, сүүлийн 10 гаруй жилд цаазаар авах ялын гүйцэтгэл нэг ч удаа хийгдээгүй байна. Үүнээс үзэхэд нийтдээ 122 улс цаазаар авах ял ногдуулах болон гүйцэтгэхээ зогсоосон байна. Бусад 74 улсад цаазаар авах ялыг ногдуулж байгаа боловч нэлээд хэд хэдэн улсад нэг жилд гүйцэтгэх тоо нь буурсан үзүүлэлт ажиглагдаж байна.

### ***Цаазаар авах ялыг дахин хэрэглэсэн орнууд***

Цаазаар авах ялыг цуцалсан улс орнуудаас зарим нэг тохиолдолд дахин хэрэглэсэн явдал гарсан байна. 1985 оноос хойш 50 гаруй улс цаазаар авах ялыг халж, ердийн болон бүх төрлийн хэргүүдэд ийм ял ногдуулахаа зогсоосон юм. Энэ хугацаанд ялын дээд хэмжээ ногдуулахыг хориглосон улс орнуудаас зөвхөн 4 улс л дахин хэрэглэжээ. Үүнд Непал, Филиппин улс орж байна. Нөгөө 2 улс болох Гамби, Шинэ Гвинейн Папуа нь одоогоор ямар ч гүйцэтгэл хийгээгүй байна.

**Гүйцэтгэлийн хэлбэр**

2000 оноос хойш дараах хэлбэрээр цаазаар авах ялыг гүйцэтгэж ирсэн байна. Үүнд: Толгойг нь авах - (Саудын Араб, Иракт)  
Цахилгаанаар цохиулах - (АНУ-д)  
Дүүжлэх - (Египт, Иран, Япон, Йордан, Пакистан, Сингапур болон бусад улсад)  
Үхлийн тариагаар тарих -(БНХАУ, Гветамал, Филиппин, Тайланд, АНУ)  
Буудах - (Беларус, БНХАУ, Сомали, Тайван, Узбекистан, Вьетнам болон бусад улс) Чулуугаар шидэх - (Афганистан, Иран)

**Насанд хүрээгүй хүнд цаазаар авах ял оногдуулах**

Олон улсын гэрээнүүдэд 18 нас хүрээгүй хэнд ч үйлдсэн хэрэгт нь цаазаар авах ял ногдуулахыг хориглосон байдаг. Энэ нь Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын Пакт, Хүний Эрхийн Америкийн Конвенц болон Хүүхдийн Эрхийн Конвенц, Женевийн конвенц зэргээр баталгаажсан байдаг. Хэдийгээр цөөн тооны улс орнууд насанд хүрээгүй хүнд цаазаар авах ял ногдуулж байгаа боловч цаазаар авах ялыг ямар нэг байдлаар хэрэглэж байгаа 110 гаруй орнууд дээрх гэрээ, конвенцуудад нэгдэн орсныхоо хувьд насанд хүрээгүй хүмүүст ялын дээд хэмжээ ногдуулахыг хориглосон байна. 1990 оноос хойш БНХАУ, Ардчилсан Конго улс, Иран, Нигер, Пакистан, Саудын Араб, АНУ, Йемен зэрэг найман улс оронд насанд хүрээгүй хүнд цаазаар авах ял ногдуулжээ. 1990-2003 оны хооронд АНУ насанд хүрээгүй 19 хүнд цаазаар авах ял оноосон нь бусад орноос давж гарсан байна.


**Гэм буруугүй хүмүүсийг цаазалсан тохиолдол**

1973 оноос хойш АНУ-д нийтдээ 122 хүнд цаазаар авах ял ногдуулсныхаа дараа гэм буруугүй болохыг нь нотлон сулласан байна. Үүнээс 2004 онд 6 хүнийг, 2005 онд 2 хүнийг сулласан байна. Нэлээд олон хүнд цаазаар авах ял ногдуулсан боловч хэргийг нь прокурор, цагдаагийн байгууллагын үл ойлголцол, эрүүл мэндийн байдал зэргээс маш удаан хугацаагаар хорьсны дараагаар гүйцэтгэсэн явдал гарчээ. Иллинойз мужийн амбан захирагч тус мужид цаазлагдсан хүмүүсээс 13 дахь хүний гэм буруугүй болохыг нь нотлогдсоны дараагаар цаазаар авах ял гүйцэтгэхийг түдгэлзүүлсэн байна. 2003 оны 1 дүгээр сард тус мужийн Амбан захирагч Риян цаазаар авах ялтай 167 хүний дөрөвт нь уучлал үзүүлж, бусдынх нь ялыг хөнгөрүүлсэн аж.

2004 онд цаазлагдсан хүний тоо ба цаазаар авах ял ногдуулсан байдал (дэлхийн улс орнуудаар) Жич: (+) нэмэх тэмдэгээр тэмдэглэгдсэн нь бодит байдал дээр илүү байж болохыг илтгэж буй юм

**Цаазаар авах ялын гүйцэтгэл**

|                       |       |
|-----------------------|-------|
| Улс орнуудаар 2005 он |       |
| Хятад                 | 1770+ |
| Иран                  | 94+   |
| Саудын Араб           | 86+   |
| АНУ                   | 60    |
| Накистан              | 31    |



Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял

|                                |       |
|--------------------------------|-------|
| Иемен                          | 24+   |
| Вьетнам                        | 21+   |
| Иордан                         | 11+   |
| Монгол                         | 8     |
| Сингапур                       | 8     |
| Кувейт                         | 6     |
| Ливи                           | 6+    |
| Палестин                       | 5     |
| Тайван                         | 3     |
| Ирак                           | 3     |
| Бангладеш                      | 3     |
| Узбекстан                      | 2+    |
| Индонез                        | 2+    |
| Өмнөд Солонгос                 | 1+    |
| Сомали                         | 1+    |
| Япон                           | 1     |
| Беларусс                       | 1+    |
| Цаазаар авах ял оноосон байдал |       |
| Улс орнууд 2005 он             |       |
| Хятад                          | 3900+ |
| Пакистан                       | 241   |
| Бангладеш                      | 218   |
| Судан                          | 135+  |
| АНУ                            | 106   |
| Филлипин                       | 104+  |
| Шри Ланк                       | 100   |
| Энэтхэг                        | 77    |
| Вьетнам                        | 65+   |
| Ирак                           | 50+   |
| Монгол                         | 27    |
| Лаос                           | 26+   |
| Афганистан                     | 24+   |
| Нигер                          | 22    |

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял

|                 |     |
|-----------------|-----|
| Иран            | 21+ |
| Тайвань         | 17  |
| Кувейт          | 14+ |
| Алжир           | 12+ |
| Йордан          | 11+ |
| Япон            | 11  |
| Этиоп           | 10  |
| Сомали          | 10  |
| Индонез         | 10  |
| Танзани         | 10+ |
| Мали            | 8   |
| Узбекстан       | 7+  |
| Марокко         | 4+  |
| Буркино Фасо    | 3   |
| Барбадос        | 2   |
| Конго           | 2   |
| Бурунди         | 2   |
| Малайз          | 2   |
| Египт           | 2+  |
| Ямайка          | 2   |
| Гвиней          | 2   |
| Өмнөд Солонгос  | 1+  |
| Сауди Араб      | 1+  |
| Хойд Солонгос   | 1+  |
| Оман            | 1+  |
| Малави          | 1+  |
| Катар           | 1+  |
| Гана            | 1   |
| Ливи            | 1+  |
| Бахрайн         | 1   |
| Тринидад Тобако | 1   |
| Белиз           | 1   |
| Йемен           | 1+  |

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял

|           |    |
|-----------|----|
| Бахама    | 1  |
| Ливан     | 1+ |
| Казакстан | 1+ |
| Сира      | 1+ |
| Сингапур  | 1+ |
| Зимбабве  | 1+ |



Foto: Scanpix/АФР

БНХАУ-д цаазаар авах ялыг гүйцэтгэх гэж буй нь

UJMN  
СУДАЛГААНЫ САН



ИИМН  
СЭДЭГ ААНЬ САН

Foto: Scanpix/APF


## 5. Цаазаар авах ялд хийсэн тандалтын судалгаа

### 5.1 Удиртгал

Энэ хэсэгт шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөн байцаагч зэрэг мэргэжлийн хуульчид ба жирийн иргэдээс цаазаар авах ялын асуудлаар санал асуулга авснаа толилуулж байна. Энэ нь цаазаар авах ялын талаархи мэргэжлийн болон олон нийтийн санал сэтгэгдэл ямар байгаа, эдгээрийн хооронд ямар зөрүү байгаа эсэхийг судлахад чиглэгдсэн болно. Монгол улсад анх удаа хийгдсэн бөгөөд ихээхэн хүч хөдөлмөр, зардал шингэсэн эл судалгаа нь цаашдаа олон судлаачдад чухал хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй.


**5.1.2 Санал асуулгад хамаарагдсан хуульчдын байдал** Санал асуулгад тус улсын 21 аймаг ба нийслэл Улаанбаатар хотын нийт 558 хуульчдыг хамааруулсан юм.

#### 1. Санал асуулгад хамаарагдсан аймаг, хотын нийт тоо болон хувь



Энэ хүснэгт эл санал асуулгад Монгол улсын 21 аймаг ба нийслэл Улаанбаатар хотод ажиллаж буй хуульчдыг хамааруулсныг харуулж байгаа болно.

#### 2. Санал асуулгад хамаарагдсан хуульчдын мэргэшил



- Шүүгч 110
- Прокурор 99
- Мөрдөн байцаагч 81
- Өмгөөлөгч 40
- Нотариатч 14
- Профессор багш 17
- Бусад 167

Эл хүснэгтээс үзэхэд санал асуулгад монголын хууль зүйн мэргэжлийн бүх төлөөллийг улс орон даяар жигд оролцуулсан нотлогдох бөгөөд тухайлбал, шүүгчид 19,9%, прокурор 17,9%, мөрдөн байцаагч 14,6%, өмгөөлөгч 7,4%, хуулийн зөвлөх 4,3%, нотариадач 2,5, профессор багш нар 3%, цагдаагийн болон ял эдлүүлэх байгууллагын албан хаагчид 30,2%-ийг эзэлж байна. Санал асуулгад оролцогчдын 57,4% нь шүүгч, өмгөөлөгч, прокурор, мөрдөн байцаагчид байгаа болно.

### 3. Санал асуулгад хамаарагдсан хуульчдын хүйсийн байдал



- Эрэгтэй 277
- Эмэгтэй 270


Санал асуулгад хамаарагдсан хуульчдын 50,6% эрэгтэй, 49,4% нь эмэгтэй байгаа нь хүйсийн тэгш байдлыг хангаж чадсан гэж үзэх үндэслэлийг буй болгосон юм.

Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял


5.1.2 Судалгаанд оролцсон иргэдийн байдал Санал асуулгад нийтдээ тус улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотод аж төрж байгаа 4344 хүнийг хамааруулав.

1. Санал асуулгад хамаарагдсан иргэдийн насны байдал:

Санал асуулгад хамаарагдсан иргэдийн насны байдлыг авч үзвэл 16-22 настай 18,4%, 23-27 настай 16,8%, 28-32 настай 14,6%, 33-41 настай 19,4%, 42-50 настай 19,8%, 50-аас дээш настай хүмүүс 11%-ийг эзэлж байна. Ийнхүү санал асуулгад хамаарагдагсдын 49,8% нь 32 хүртлэх насны хүмүүс байгаа юм.




2. Санал асуулгад хамаарагдсан иргэдийн хүйсийн байдал




асуулгад хамаарагдсан иргэдийн 45,2% нь эрэгтэйчүүд, 54,8% нь эмэгтэйчүүд байна.





## 3. Санал асуулгад хамаарагдсан иргэдийн боловсролын байдал:



Санал асуулгад оролцсон иргэдийн 24,9% нь бага, дунд боловсролтой, 25,3% нь тусгай дунд боловсролтой, 49,8% дээд боловсролтой юм. / Хавсралт 6-аа үзнэ үү /




4. Санал асуулгад хамаарагдсан иргэдийн ажил эрхлэлтийн байдал:



Санал оролцсон иргэдийн 46,1% нь төрийн байгууллагад, 21,5% нь хувийн секторт, 18% нь сурагч, оюутан, 14,4% нь ажил хөдөлмөр эрхлээгүй хүмүүс байсан байна./ хавсралт 7-оос үзнэ үү /



## 5. Санал асуулгад оролцсон иргэдийн хамаарагдсан газар:



|              |              |            |               |            |              |
|--------------|--------------|------------|---------------|------------|--------------|
| □ Баянхонгор | ■ Дорнод     | ▣ Ховд     | □ Дорноговь   | ▣ Орхон    | ■ Завхан     |
| ■ Дархан-Уул | □ Увс        | ■ Сэлэнгэ  | □ Төв         | □ Архангай | □ Хэнтий     |
| ■ Сүхбаатар  | ▣ Баян-Өлгий | ▣ Хөвсгөл  | ■ Говь-Алтай  | □ Булган   | □ Өвөрхангай |
| □ Дундговь   | □ Говьсүмбэр | □ Өмнөговь | □ Улаанбаатар |            |              |

Энэ хүснэгтээс үзэхэд санал асуулга явуулсан газар нь тус улсын нийт аймаг ба нийслэл хотыг жигд хамарч чадсан байна.


## 5.2 Мэргэжлийн хуульчдын хандлага

Санал асуулгын асуултад хуульчдын өгсөн хариултын үзүүлэлт

## 5.2.1 Цаазаар авах ялын тухай мэдлэг



5.2.2 Цаазаар авах ял байлгах шаардлагатай эсэх



5.2.3 Цаазаар авах ялыг халах үндэслэгээ

5.2.3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлж чадахгүй



- тийм: 41/7.4%
- үгүй: 517/92.6%

5.2.3.2. Хэтэрхий харгис шийтгэл:



- тийм: 30/5.3%
- үгүй: 528/94.7%



5.2.3.3. Хүнийг хилсээр шийтгэх эрсдэлтэй атлаа шийдвэрийг засах боломжгүй:




– үгүй: 472/84.8%                      — тийм: 85/15.2%

5.2.3.4 Ялын бодлогыг хүмүүнлэг, энэрэнгүй болгох ёстой:



– тийм: 49/8.7%  
– үгүй: 508/91.3%

5.2.3.5 Хүний амьд явах эрхэд халдаж байна:



– тийм: 55/9.8%  
– үгүй: 403/77.2%

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

---

Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял

---


5.2.3.6. Ялын зорилготой нийцэхгүй байна:



|         |           |
|---------|-----------|
| - тийм: | 18/3.2%   |
| - үгүй: | 540/96.3% |


5.2.4 Цаазаар авах ялыг хэвээр байлгах үндэслэгээ

5.2.4.1 Ерөнхий урьдчилан сэргийлэлт болж чадна:



|         |           |
|---------|-----------|
| - тийм: | 127/22.7% |
| - үгүй: | 431/77.3% |


4.2.4.2 Нийгмийг цэвэршүүлнэ:



|         |           |
|---------|-----------|
| - тийм: | 115/20.6% |
| - үгүй: | 443/79.4% |


UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

5.2.4.3 Улс орны өнөөгийн эрүүгийн нөхцөл хүнд байгаа учир:




- тийм: 170/30.4%
- үгүй: 388/69.6%

5.2.4.4 Цаазаар авах ялыг халахыг нийгэм хүлээн зөвшөөрөхгүй:



- тийм: 11/20.6%
- үгүй: 443/79.4%

5.2.4.5 Ноцтой хүн амины хэрэгт цаазаар авах ял нь шударга ёсыг тогтоож өгдөг:




- тийм: 331/59.3%
- үгүй: 227/40.7%

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

5.2.5 Дагаж мөрдөж буй Эрүүгийн хуульд цаазаар авах ял шийтгэхээр тогтоосон гэмт хэрэгт ийм ял ногдуулах нь зөв эсэх талаар өгсөн үндэслэгээ

5.2.5.1 Төр, нийгмийн зүтгэлтэний амь биед халдах:




|          |           |
|----------|-----------|
| – Зөв:   | 393/70.5% |
| – Буруу: | 164/29.5% |

5.2.5.2 Хорлон сүйтгэх:



|          |           |
|----------|-----------|
| – Зөв:   | 375/67.4% |
| – Буруу: | 181/32.6% |


5.2.5.3 Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг санаатай алах:



|          |           |
|----------|-----------|
| – Зөв:   | 455/81.6% |
| – Буруу: | 102/18.4% |


UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

5.2.5.4 Онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх:




- Зөв: 409/73.4%
- Буруу: 148/26.6%

5.2.5.5 Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар зандалчлах:



- Зөв: 338/60.6%
- Буруу: 219/39.4%

5.2.5.6 Төрлөөр устгах:



- Зөв: 453/81.4%
- Буруу: 103/18.6%

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**


Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял

5.2.6 Онц ноцтой гэмт хэргийн гаралтыг бууруулахад цаазаар авах ял нөлөөлж чадах эсэх



- чадна: 364/65.9%
- чадахгүй 137/24.8%
- мэдэхгүй: 51/9.3%

5.2.7 Ерөнхийлөгчөөс уучлал үзүүлэх нь



- зөв: 318/57.8%
- буруу: 195/35.4%
- Мэдэхгүй: 37/6.8%

5.2.8 Цаазаар авах ялын гүйцэтгэлийг нууцлах нь:




- шаардлагатай:271/49.3%
- шаардлагагүй:237/43.2%
- Ингэх нь маш буруу:27/4.9%
- Мэдэхгүй: 14/2.6%





5.2.9 Цаазаар авах ялыг нийтийн өмнө гүйцэтгэхийг:



- дэмжинэ: 249/45.1%
- дэмжихгүй: 302/54.9%

5.2.10 Цаазаар авах ялыг бүх насаар нь хорих ялаар солих нь хэр зэрэг үр нөлөөтэй эсэх:



- Цаазаар авах ял илүү үр нөлөөтэй: 229/41.5%
- Бүх насаар нь хорих ял илүү үр нөлөөтэй: 88/16%
- Хослуулан хэрэглэх нь зөв: 200/36.3%
- Мэдэхгүй: 34/6.2%

5.2.11 Цаазаар авах ялыг эмэгтэйчүүдэд ногдуулахыг хориглосон заалт нь:

5.2.11.1 Энэрэнгүй ёсны зарчимд нийцнэ:



- тийм: 406/73.5%
- үгүй: 146/26.5%

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН


Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял

5.2.11.2 Тэгш эрхийн зарчимтай зөрчилдөнө:




- тийм: 92/16.5%
- гүй: 465/83.5%

5.2.11.3 Манай орны нөхцөлд цаазаар авах нь зүйтэй:



- тийм: 16/2.8%
- гүй: 542/97.2%

5.2.12 Эл ялын гүйцэтгэлийн талаар мэдээлэл авдаг эх сурвалж:



### 5.2.13 Цаазаар авах ял ногдуулах талаар шүүхээс баримтлах бодлого:



### 5.2.14 Төрөөс цаазаар авах ялын талаар баримтлах бодлого:



## 5.3 Олон нийтийн хандлага

### Судалгаанд хамрагдсан иргэдийн үндсэн үзүүлэлтүүд

Судалгаанд хамрагдсан иргэдээс дараахи асуултаар цаазаар авах ялын талаархи тэдний санал бодлыг тандсан юм.


### 5.3.1 Цаазаар авах ялыг байлгах шаардлагатай эсэх



5.3.2 Цаазаар авах ялыг эмэгтэйчүүдэд ногдуулах эсэх:



5.3.3 Ерөнхийлөгчөөс уучлал хүсэх нь:



5.3.4 Цаазаар авах ялыг олны өмнө гүйцэтгэх нь:



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

5.3.5 Цаазаар авах ялыг халах үндэслэгээ

5.3.5.1 Нийгмийн зан суртахууныг энэрэнгүй бус болгоно:




5.3. 5.2 Хэт харгис шийтгэл:



5.3.5.3 Хүнийг хилсдүүлбэл алдааг нь засах боломжгүй:



5.3.5.4 Харгислал, харгислалыг төрүүлдэг:



5.3.5.5 Хүний амьд явах эрхтэй зөрчилдөнө:



5.3.6 Цаазаар авах ялыг хэвээр хадгалах үндэслэгээ

5.3.6.1 Бусдад сургамж болно:



UIH.MN  
СҮНДЭЛГ ААНЫ САН

5.3.6.2 Нийгмийг цэвэршүүлнэ:



5.3.6.3 Ноцтой гэмт хэрэгт тохирсон ял ногдуулах нь зөв:



5.3.6.4 Шударга ёсыг тогтооно:




UIH.MN  
СЭДАЛГААНЫ САН


5.3.6.5 Өшөө авах нь зөв:



5.3.7. Төрөөс цаазаар авах ялын талаар баримтлах бодлого:




5.3.8. Цаазаар авах ял ногдуулсан тухай мэдээлэл олж авах эх сурвалж:







4.3.9. Цаазаар авах ял ногдуулсан тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах эсэх:



5.3.10. Цаазаар авах ял нь хүний амьд явах эрхэд халдаж байна гэж зарим хүмүүс үздэг. Энэ талаар таны бодол



5.3.11. Ноцтой гэмт хэрэгт цаазаар авах ялын оронд бүх насаар нь хорих ялаар шийтгэдэг хууль зарим оронд байдаг. Энэ хоёр төрлийн ялын алийг нь та дэмжих вэ?



5.3.12. Та болон таны гэр бүлийнхэн, ойр дотны хэн нэгэн ноцтой гэмт хэрэгт хохирч байсан уу?



5.3.13. Таны ойр дотны болон танидаг хүмүүсийн хэн нэг нь цаазаар авах ялаар шийтгүүлсэн тохиолдол бий юу?



UJ.MN  
ЭЗЭМ ААНЫ САН

#### 5.4. Дүгнэлт

Санал асуулгаар мэдэж авсан нэн чухал асуудлыг дараахи байдлаар тоймлон илэрхийлж, нэгтгэн дүгнэж болохоор байна.

Санал асуулгад оролцсон **хуульчдын цаазаар авах ялын тухай мэдлэгийг 5.2.1-ийн асуулгаар тандахад** нийт оролцогчдын 65,4% хувь нь цаазаар авах ялын талаар зөвхөн суралцаж байхдаа буюу амьдралаас олж авсан мэдлэгтэй байгаа болох нь харагдсан. Энэ учраас хуульчид ялангуяа шүүгчид, мөрдөн байцаагчид, прокурор, өмгөөлөгчдийн цаазаар авах ялын талаархи онолын мэдлэг, бэлтгэлийг дээшлүүлэх шаардлагатай байгаа юм байна.

**5.2.2-ын асуулгаар хуульчдаас цаазаар авах ялыг хэвээр байлгах эсэх асуудлаар** тэдний санал бодол ямар байгааг тандахыг оролдсон болно. Санал асуулгад оролцсон нийт хуульчдын 83, % цаазаар авах ялыг хэвээр байлгах шаардлагатай хэмээн үзсэн байна. Харин зөвхөн 13,8% нь цаазаар авах ялыг халах чиглэлийг баримжаалж байгаа нь ялангуяа шүүгчид, өмгөөлөгч нарт эрүүгийн эрх зүйн хүмүүнлэг боловсрол, мэдлэг олгох шаардлагыг нөхцөлдүүлж байна. Энэ үзүүлэлт иргэдийн хувьд хуульчидтай их ойролцоо гарсан (үз. 5.3.1) бөгөөд цаазаар авах ялыг байлгах онц шаардлагатай, шаардлагатай гэсэн хувилбараар тандахад 16,8% онц шаардлагатай, 62,8% шаардлагатай хэмээн хариулсан байна.

**Цаазаар авах ялыг халах үндэслэгээг хуульчдаас 5.2.3, харин иргэдээс 5.3.5-ын асуулгаар тандахыг зорьсон болно:**

- **5.2.3.1-ийн асуулгаар санал асуулгад оролцсон хуульчдын 92,6% цаазаар авах ялыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нөлөө үзүүлж чадна гэж үзжээ.**

- Санал асуулгад оролцсон хуульчдын 94,7% нь **5.2.3.2-ын асуулгад хариулахдаа цаазаар авах ялыг хэт харгис хэрцгий ял хэмээн үзээгүй байна.** “нүдийг нүдээр, шүдийг шүдээр” хэмээдэг дундад зууны өс авах сэтгэхүй хуульчдын дунд нэлээд газар авсныг эл үзүүлэлт харуулж байна.

- Цаазаар авах ял хүнийг хилсдүүлэх эрсдэлийг өөртөө цаг ямагт агуулж, хэрэв ялын гүйцэтгэлийг нэгэнт хэрэгжүүлсэн бол түүнийг засаж залруулах ямар ч боломжгүй нь хэн ч маргахын аргагүй бодит үнэн юм. Гэтэл **5.2.3.3-ын асуулгад хариулт өгсөн хуульчдын 84,8% нь ийм бодит байдлыг үгүйсгэж байгааг анхааралтай авч үзэх ёстой болж байна.**

- **5.2.3.4-ын асуулгаар санал асуулгад оролцсон хуульчдын 91,3% ялын бодлогыг хүмүүнлэг, энэрэнгүй болгохоос татгалзсан хариулт өгчээ.** Энэ нь хуульчдын мэдлэг, сэтгэлгээнд орчин цагийн хүмүүнлэг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнээс ихээхэн гажууд үзэл бодол байгааг харуулж байна.

- Санал асуулгад оролцсон хуульчдын 77,2% цаазаар авах ялыг хүний амьд явах эрхэд халдаагүй гэж **5.2.3.5-ын асуулгаар хариулсан байна.** Энэ нь хүний эрхийн тухай мэдлэг хуульчдад хангалтгүй байгааг харуулж байна. Иргэдийн хувьд эл үзүүлэлт бүр өндөр гарсан бөгөөд санал асуулгад оролцсон иргэдийн 86,3% цаазаар авах ялыг хүний эрхтэй зөрчилдөхгүй хэмээн үзсэн байна. (үз. 5.3.5.5)

- Санал асуулгад оролцсон хуульчдын 96,8% цаазаар авах ялыг ялын зорилгод нийцэж байна гэж 5.2.3.6-т дурдсан асуултаар үзжээ. Гэтэл хэрэгтнийг засан хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг ялын зарим зорилго огт хэрэгждэггүй болох тухай мэдлэг хуульчдын хувьд туйлын хангалтгүй байгаа болохыг эл үзүүлэлт харуулж байна.

- Санал асуулгад оролцсон иргэдийн 90,8% цаазаар авах ял нийгмийн зан суртахууныг энэрэнгүй бус болгоно гэсэн асуултад тийм биш гэсэн хариулт өгчээ (үз. 5.3.5.1). Тэрчлэн 92,7% цаазаар авах ялыг хэт харгис шийтгэл хэмээн үзээгүй, 92,5% харгислал харгислалыг төрүүлдэггүй хэмээн үзжээ. (үз. 5.3.5.2, 5.3.5.4) Эдгээр нь иргэдийн ухамсарт цаазаар авах ялын сөрөг тал, эрсдлийн талаар буруу ойлголт газар авсныг харуулж байна.

**Цаазаар авах ялыг цаашид хэвээр хадгалах үндэслэгээг хуульчдаас 5.2.4.1-5.2.4.5, иргэдээс 5.3.6.1- 5.3.6.5-т дурдсан асуултаар тандахыг зорьсон болно:**

- Санал асуулгад оролцсон хуульчдын 77,3% цаазаар авах ялыг нийт хүмүүст гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх сургамж болж чадахгүй хэмээн 5.2.4.1-ийн асуултаар үзсэн байна. Санал асуулгад оролцсон иргэдийн 58,7% мөн ийм үзэл бодолтой байгаа юм байна. (үз. 5.3.6.1)

- Санал асуулгад оролцсон хуульчдын 79,4% цаазаар авах ялыг нийгмийг “үл бүтэх” этгээдүүдээс цэвэршүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж 5.2.4.2-ын асуултаар хүлээн зөвшөөрөөгүй байна. Энэ талаархи иргэдийн үзэл бодол ч үүнтэй их ойролцоо байна (үз. 5.3.6.2)

- Улс оронд хүнд, онц хүнд гэмт хэргийн гаралт нэмэгдэж, эрүүгийн нөхцөл байдал хүндэрч байгаа нь цаазаар авах ялыг хэвээр хадгалах нэг гол шалтгаан болохыг санал асуулгад оролцсон хуульчдын 69,6% нь 5.2.4.3-ын асуултаар хүлээн зөвшөөрөөгүй байна.

- Санал асуулгад оролцсон нийт хуульчдын 20 орчим хувь нь цаазаар авах ялыг халахыг нийгэм зөвшөөрөхгүй гэж үзсэн байна. Харин 80 шахам хувь нь цаазаар авах ялыг цуцлахад нийгэм хүлээн зөвшөөрнө гэсэн санааг илэрхийлснийг 5.2.4.4 харуулж байна.

- Санал асуулгад оролцсон иргэдийн 72,7% цаазаар авах ял нь шударга ёсыг нийгэмд тогтооход онцын нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн хариулт өгчээ. (үз. 5.3.6.4) Цаазаар авах ялыг өс авах хэрэлүүр болгохыг иргэдийн 98,6% хүлээн зөвшөөрөөгүй байна. (үз. 5.3.6.5) Эдгээр үзүүлэлт нь хуульчдаас илүү зан суртахууны мэдрэмжтэй байгааг нотлон харуулж байна.

Мэргэжлийн хуульчид дагаж мөрдөж буй Эрүүгийн хуульд тодорхой гэмт хэрэгт тогтоосон цаазаар авах ялын талаар ямар санал бодолтой байгааг 5.2.5-ын асуултаар тандсан болохыг 5.2.5.1-5.2.5.6 гэсэн асуултаас тодруулж үзнэ үү?

Онц ноцтой гэмт хэргийн гаралтыг бууруулахад цаазаар авах ял нөлөөлж чадах эсэх талаар тандахад санал асуулгад оролцсон хуульчдын 65,9% нь чадна хэмээн хариулсныг 5.2.6 харуулж байна. Энэ үзүүлэлт иргэдийн хувьд 51,2%-тай байна. (үз. 5.3.6.3)

Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд **Ерөнхийлөгч уучлал** үзүүлж байгааг санал асуулгад оролцсон хуульчдын 57,8% зөв зүйтэй хэмээн үзжээ. (үз. 5.2.7) Иргэдийн 54,8% Ерөнхийлөгчөөс уучлал үзүүлэхийг дэмжихгүй байгаагаа илэрхийлжээ (үз. 5.3.3).

**Цаазаар авах ялын гүйцэтгэлийг нууцлах** шаардлагатай гэж санал асуулгад оролцсон хуульчдын 49,3% үзсэн бол 43,2% нууцлах шаардлагагүй гэсэн байна. (үз. 5.2.8) Санал асуулгад оролцсон иргэдийн 61% нь цаазаар авах ял ногдуулсан тухай мэдээллийг нээлттэй байлгах шаардлагатай хэмээн үзжээ. (үз. 5.3.9)

**Цаазаар авах ялыг нийтийн өмнө гүйцэтгэхийг** санал асуулгад оролцсон хуульчдын 54,9% дэмжихгүй гэдгээ илэрхийлжээ. (үз. 5.2.9) Харин иргэдийн 39,5% мөн дэмжихгүй байгаагаа, 11,6% мэдэхгүй гэдгээ илэрхийлжээ. (үз. 5.3.4)

**Цаазаар авах ялыг халж түүний оронд бүх насаар нь хорих ял тогтоох** талаар хуульчид ба иргэдийн санал бодол ямар байгааг тандах зорилтыг судалгааны явцад тавьсан болно. Цаазаар авах ял ба бүх насаар нь хорих ялыг хослуулан сонгож хэрэглэхийг санал асуулгад оролцсон хуульчдын 36,3%, иргэдийн 32,1% дэмжжээ. (үз. 5.2.10 ба 5.3.11) Харин санал асуулгад оролцсон иргэдийн 22,3% бүх насаар хорих ялыг дэмжиж байгаагаа илэрхийлжээ. (үз. 5.3.11)

**Цаазаар авах ялын талаар мэдээлэл олж авах эх сурвалж** нь санал асуулгад оролцсон хуульчдын 30,2%-д албан ажлын шугамаар, 27,3%-д хэвлэл, мэдээллийн хэрэгслээс, 10,6%-д бусдын ам дамжсан ярианаас харин 25,8% буюу санал асуулгад оролцогчдын дөрөвний нэгээс илүү нь энэ талын мэдээлэл авах боломжгүй байдгаа илэрхийлжээ. (үз. 5.2.12) Харин иргэдийн хувьд 11,4% шүүх хуралдаанаас, 50,4% сонин хэвлэлээс, 29,1% телевиз, радиогоос, 15,8% бусдын ам дамжсан яриагаас, 2,8% интернетээс олж авдаг гэжээ. (үз. 5.3.8) Санал асуулгад оролцсон иргэдийн 15,8% энэ талын мэдээлэл авах боломжгүй байдаг хэмээн хариулжээ.

**Шүүхээс цаазаар авах ял ногдуулах талаар баримтлах бодлогын** талаар хуульчид ямар санал сэтгэгдэлтэй байдгийг 5.2.13-аар тандахад санал асуулгад оролцогчдын 45,3% одоогийн ялын бодлого тохирч байна хэмээн үзсэн бол харин 16,8% ялын бодлогыг зөөлрүүлж, цаазаар авах ялыг аль болохоор хэрэглэхгүй байх нь зүйтэй гэж үзжээ.

**Төрөөс цаазаар авах ялын талаар баримталж буй өнөөгийн бодлогыг** санал асуулгад оролцсон хуульчдын 40,1% тохирсон, 17,7% цаазаар авах ялыг аажмаар халах, 13,2% цаазаар авах ялыг цөөлөх (үз. 5.2.14) гэж үзсэн бол хуульчдын 29%, иргэдийн 24,2% (үз. 5.3.7) цаазаар авах ялыг хэрэглэх хүрээг өргөжүүлэх санал гаргажээ. Энэ чиглэлээр иргэдийн үзэл бодол ямар байгааг харуулбал, санал асуулгад оролцсон иргэдийн 25,8% одоогийн бодлого тохирч байна гэж үзжээ. (үз. 5.3.7) Гэтэл энэ байдал хуульчдын хувьд 40,1% байгааг өмнө тэмдэглэсэн билээ. Цаазаар авах ялыг халах нь зүйтэй гэж 8,7% үзжээ. Цаазаар авах ял ногдуулах боловч гүйцэтгэлийг нь түдгэлзүүлэх нь зүйтэй гэж санал асуулгад оролцогчдын 24% үзсэн байна. Төрийн бодлого ямар байх талаар иргэдийн 17,3% мэдэхгүй гэсэн хариулт өгчээ (үз. 5.3.7).

Санал асуулгын явцад иргэдээс - **та ба таны гэр бүлийнхэн, ойр дотнын хүмүүс ноцтой гэмт халдлагын хохирогч болж байсан эсэх** талаар асуухад –тийм гэж 11,6% нь хариулжээ. Эндээс үзэхэд эл асуултад хариулт өгсөн 4294 иргэдийн 10 гаруй хувь буюу өөрөөр хэлбэл, 449 иргэн ноцтой гэмт халдлагын хохирогч болж байжээ. (үз. 5.3.12) Тэрчлэн санал асуулгад оролцсон иргэдийн 4% буюу 172 иргэний ойр дотнын ба танидаг хүмүүсийн хэн нэгэн нь цаазаар авах ял шийтгүүлж байжээ(үз. 5.3.13).

## 6. Зөвлөмж

**Шүүн таслах ажиллагааны хүрээнд** шүүхийн шийтгэх тогтоолоор ногдуулсан гүйцэтгэх хугацааг 3 хүртэл жилийн хугацаагаар хойшлуулж, эцэслэн хянах журмыг хуульчлан тогтоох журамд шилжих саналыг зөвлөмж болгож байна.

☞ Цаазаар авах ял шийтгүүлсэн хүний хэргийг хяналтын журмаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр гомдол гаргасан эсэхийг харгалзахгүйгээр хянан хэлэлцэж байгаа билээ. Ийнхүү цаазаар авах ял ногдуулсан шүүхийн тогтоолыг давж заалдах шатанд хянагдсан эсэхээс үл хамаарч, заавал Улсын дээд шүүхийн хяналтын шатаар хянах журмыг 1993 оноос эхлэн тогтоон хэрэгжүүлсэн нь Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын “Энэхүү шийтгэлийг гагцхүү эрх бүхий шүүхээс гаргасан таслан шийдвэрлэх эцсийн тогтоолыг биелүүлэх замаар хэрэгжүүлж болно” гэсэн заалттай нийцэж байгаа юм. Тийм учраас эл маш зөв практикийг хэвээр хадгалах нь чухал.

☞ Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн мөрдөн байцаалтын хийгээд шүүн таслах ажиллагаа олон сар, жилээр удаашран үргэлжилж, энэ нь эцсийн дүндээ хүнийг зовоон тарчлаах нэгэн хэлбэр болж байгааг онцгой анхаарах цаг болжээ.

☞ Цаазаар авах ял ногдуулж болзошгүй хэргийн мөрдөн байцаалт ба шүүх хуралдаанд өмгөөлөгч заавал оролцуулж байх тухай Монгол улсын ЭБШХ-ийн холбогдох заалтыг ягштал дагаж мөрдөх шаардлагатай байна.

☞ Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийг хорих нөхцөл, тэдэнтэй хүнлэг, энэрэнгүй харьцах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, эл ялыг ял шийтгүүлэгчийн ойр дотнын хүмүүст халдаан хэрэглэх явдлыг арилгах нь нэн чухал.

Цаазаар авах ялаар шийтгүүлсэн байдлыг төрийн нууцад хамааруулж, олон нийтээс нууцалж байгаа одоогийн нөхцөл байдлыг өөрчлөхийг зөвлөмж болгож байна.

**Уучлал үзүүлэх хүрээнд** цаазаар авах ялыг уучлан амь хэлтрүүлэх явдлыг улс төрийн нөлөөлөл, нийгмийн сэтгэл зүйгээс үүдэн гардаг аливаа нөлөөлөл, шахалтаас ангид байлгаж, зөвхөн хүмүүнлэг, энэрэнгүй ёсны үүднээс хандаж шийдвэрлэж байх нь зүйтэй юм

**Эрх зүйн боловсролын хүрээнд** тус улсын хууль зүйн их дээд сургуулийн ба давтан сургалтын эрүүгийн эрх зүйн хичээлийн хөтөлбөрт цаазаар авах ялын онолын ба практикийн тулгамдсан асуудлыг сайтар тусгах, хуульчдын энэ талын мэдлэгийг дээшлүүлэх асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй.

**Соён гэгээрүүлэх хүрээнд** хуульчид ба иргэдэд хүмүүнлэг, энэрэнгүй ёсны үзэл, итгэл үнэмшил төлөвшүүлэхийн тулд сургалт, сурталчилгааны олон талт ажил зохиох шаардлагатай байгааг судалгааны дүн харууллаа.

**Монгол улсын хуулинд заасан цаазаар авах ялыг бүрэн устгахын тулд** Эмнести Интернэшнл байгууллагаас цаазаар авах ял оноох болон цаазаар авах ялын гүйцэтгэлүүдийг яаралтай хойшлуулах нь хүний амьд явах үндсэн эрхийг хамгаалахад чухал алхам болно гэдгийг зөвлөмж болгож байна. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээний наад захын шаардлагад нийцүүлэн Монгол улс нь цаазаар авах ялыг “зөвхөн онц ноцтой хүнд гэмт хэргүүдэд” (Иргэний болон Улс төрийн Эрхийн Олон Улсын Пактын 6-2) оноох"-ыг шаардаж байна. “Онц ноцтой хүнд гэмт хэрэг”-ийн цар хүрээ нь урьдчилан төлөвлөсөн аллага, санаатайгаар болон урьдаас төлөвлөсөн хүн алахыг завдсан гэмт хэргүүдээр хязгаарлагддаг. Монгол улсын хуулинд байгаа хүний үндсэн эрхийн шаардлагад нийцээгүй бүх зүйл, заалтуудыг устгах ёстой.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын фактын энэ шаардлага нь “цаазаар авах ял нь онцгой арга хэмжээ байх ёстой” гэдгийг НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос тогтоож өгсөн байна. (Хүний Эрхийн Хороо, Ерөнхий тайлбар 6, Зүйл 6 ( 1982 он 16 дугаар чуулган), параграф-7; Хүний Эрхийн Гэрээний талуудаар батлагдсан Ерөнхий Тайлбар ба Ерөнхий Зөвлөмжүүдийн Эмхтгэл, НҮБ-ын Баримт бичиг)

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН